




Сургуулийн өмнөх
боловсролын байгууллагын
багшид зориулсан



Бага насны хүүхдийг
хүчирхийллээс урьдчилан сэргийлэх,
хамгаалах, мэдлэг, чадвар олгох
сургалтын модуль



Товчилсон үгийн тайлбар:

БСШУСЯ	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МОНЭС	Монголын эмэгтэйчүүдийн сан
МУБИС	Монгол Улсын Боловсролын их сургууль
МУ	Монгол Улс
НБГ	Нийслэлийн боловсролын газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ДОХ	Дархлалын Олдмол Хомсдол
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар

Хэрэгжүүлэгч байгууллага



Хамтрагч байгууллагууд



СОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХЛААН,
СПОРТЫН ЯАМ



ГЭР БИЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН
Хөгжлийн Газар



Сургуулийн өмнөх
боловсролын байгууллагын
багшид зориулсан

Бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдлэг, чадвар олгох сургалтын модуль

2019 он

Э

нэхүү сургалтын модулийг “Ананда” олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид байх орчинг дэмжих нь” төслийн хүрээнд бага насны хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хамгаалах талаар олон нийт (хүүхэд, эцэг эх, багш) болон олон талт оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулав.

Энэхүү сургалтын модулийг БСШУСЯамны харьяа Боловсролын Хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлөөр хянуулсан болно. Тус сургалтын модуль нь санхүүжүүлэгч байгууллагын байр суурийг илтгэхгүй. Сургалтын модулийг хэсэгчлэн болон бүрэн ашиглах тохиолдолд эх сурвалжийг заавал дурдана уу.

Модулийн талаарх санал хүсэлтээ дараах хаягаар явуулна уу:

Сүхбаатар дүүрэг, 6-р хороо
Бага тойруу 48-р байр, 305 тоот
Улаанбаатар -46А, Ш/Х 280
Улаанбаатар
Монгол улс

Цахим хаяг: mones@mongol.net

Утас: +976 7711-9991

2

дахь хэвлэл

Боловсруулсан: Б.Мөнхзаяа, НБГ-ын СӨБ, цэцэрлэгийн багшийн хөгжил хариуцсан мэргэжилтэн
А.Амартүвшин, Улаанбаатар, 5-р цэцэрлэгийн арга зүйч
Х.Даринчулуун, Улаанбаатар, 57-р цэцэрлэгийн арга зүйч
Л.Бадамцэцэг, ГБХЗХГ-ын Гэр бүл, хөгжлийн газрын мэргэжилтэн
Л.Ариунзул, МОНЭС-гийн төслийн зохицуулагч

Зөвлөхүүд: Н.Оюунбат, БСШУЯ-ны СӨБ-ын агуулга, стандарт, хөтөлбөрийн бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
С.Болормаа, БСШУЯ-ны Хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгаалал, үйлчилгээний хүртээмж, хэрэглэгдэхүүн орчны аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
Д.Нонна, МУ-ын гавьяат багш, МУБИС-ийн хүндэт профессор
П.Цэвээн, “Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ” ТББ зохицуулагч,
Хүүхдийн эрхийн үндэсний төвийн Тэргүүн
О.Гэрлээ, “Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд” ТББ-ын зохицуулагч, Бэлгийн боловсролын үндэсний шинжээч
Б.Эрдэнэчимэг, МОНЭС-гийн Гүйцэтгэх захирал

Хамтран ажилласан: Архангай аймгийн 8-р цэцэрлэгийн хамт олон
Архангай аймгийн Чулуут сумын цэцэрлэгийн хамт олон
Баянхонгор аймгийн 10-р цэцэрлэгийн хамт олон
Баянхонгор аймгийн Богд сумын цэцэрлэгийн хамт олон
Баянгол дүүргийн 114-р цэцэрлэгийн хамт олон
Баянзүрх дүүргийн 6-р цэцэрлэгийн хамт олон
Багануур дүүргийн 139-р цэцэрлэгийн хамт олон
Дорнод аймгийн 12-р цэцэрлэгийн хамт олон
Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын хамт олон
Хан-Уул дүүргийн 28-р цэцэрлэгийн хамт олон
Сонгинохайрхан дүүргийн 117-р цэцэрлэгийн хамт олон

Зураач:

Б.Гантулга

ӨМНӨХ ҮГ

Монголын Эмэгтэйчүүдийн Сан (МОНЭС) нь эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллага, бүлгүүдэд эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн төлөө санхүүгийн дэмжлэг үзүүлдэг ҮНДЭСНИЙ АНХДАГЧ САН юм.

МОНЭС нь 2000 онд байгуулагдсан цагаасаа хойш охид эмэгтэйчүүдийн эрхийг хангах, жөндөрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудлыг үйл ажиллагааныхаа нэг гол чиглэл болгон ажиллаж байгаа билээ.

Бид 2017 оноос эхлэн “Ананда” Олон улсын байгууллагын санхүүжилтээр “Бага насны хүүхдийн хүчирхийллээс ангид орчинг дэмжих нь” төслийг гурван жилийн хугацаатай Улаанбаатар хот, Архангай, Баянхонгор, Дорнод аймгийн 11 цэцэрлэгт хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Нийслэлийн Боловсролын Газар, Гэр бүл, Хүүхэд Залуучуудын Хөгжлийн Газар, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Хөөрхөн зүрхнүүдийн аян, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.

Бага насны хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хамгаалах талаар олон нийт (хүүхэд, эцэг эх, багш) болон олон талт оролцогчдын, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд сургуулийн өмнөх боловсролын багш нарт зориулсан “Бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах мэдлэг, чадвар олгох нь” сэдэвт 16 цагийн сургалтын модуль боловсруулан та бүхэнд толилуулж байна. Сургалтын модуль нь сургагч багш нарыг хүний эрх, хүүхдийн эрх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар сургалт явуулах

арга зүйгээр хангах, эцэг эх, багш нарт хүмүүжлийн эерэг аргын талаар ойлголт мэдлэг өгөх төдийгүй 4-5 настай хүүхдүүдэд болзошгүй хүчирхийллээс өөрийгөө хэрхэн хамгаалах талаар сургалт явуулах арга зүйг танилцуулж байгаа билээ. Энэ модуль нь сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөртэй нягт уялдуулан боловсруулсан бөгөөд хүүхдэд хүчирхийллээс өөрийгөө хамгаалах талаар сургалтын олон төрлийн хэрэглэгдэхүүн ашиглаж өгч байгаагаараа шинэлэг гэж зохиогчид үзэж байгаа юм.


Монголын эмэгтэйчүүдийн сан нь төрийн бус байгууллагууд, цэцэрлэгүүдийн арга зүйч, багш нартай хамтран хот хөдөөгийн 11 цэцэрлэг дээр цуврал сургалт явуулан туршиж, багш, мэргэжилтнүүдийн саналыг тусган, сургалтын модулийг дахин сайжруулж, хоёр дахь удаагаа хэвлүүлж байна

Бидний боловсруулсан сургалтын модуль бага насны хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгоход чухал хувь нэмэр оруулах төдийгүй сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хүүхдийг хүчирхийллээс ангид байх орчин бүрдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Хүүхэд бүр хүчирхийллээс ангид байг!

Монголын эмэгтэйчүүдийн сан

**Сургалтын
модулийг
ашиглах
заавар**



Энэхүү сургалтын модульд: эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан 4 цагийн агуулга, 4-5 настай хүүхдүүдэд зориулсан 4 цагийн хичээл тус тус багтсан. Хичээл бүрт тухайн сэдвийн зорилго, түүнээс хүлээгдэж байгаа үр дүн, хэрхэн заах аргазүй/цагийн хуваарилалтыг багтаасан хөтөлбөр, шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг тодорхой тусгаж орууллаа. Ингэснээр цэцэрлэгийн багш сургалтын модулийг уншиж, зааврын дагуу сургалтыг бие даан хөтлөн явуулах боломжтой.

Энэхүү модулиар бага насны хүүхдэд сургалт явуулахын өмнө тэдний эцэг эх/асран хамгаалагчдыг сургалтад хамруулж, бага насны хүүхэдтэйгээ хүчирхийллийн асуудлаар ярих арга зүйд сургаж, урьдчилан бэлтгэх нь чухал юм.

Эцэг эх/асран хамгаалагчдад зориулсан 4 цагийн сургалтыг нэг удаа зохион байгуулахаас илүүтэй, хоёр цагаар хоёр удаа эсвэл нэг цагаар дөрвөн удаагийн сургалтыг зохион байгуулбал илүү тохиромжтой. Уг номонд, хичээл бүрийн хөтөлбөрийг цаг, минутад хуваарилж оруулсан тул та бүхэн эцэг эх/асран хамгаалагчдынхаа онцлог, мэдлэг, чадварт тохируулан хэрхэн зохион байгуулахаа сонгох боломжтой. Түүнчлэн, дөрвөн цагийн сургалтад эцэг эх/асран хамгаалагчдаа бүтэн хамруулж байж сая цогц мэдлэг олж авч чадна гэдгийг тэмдэглэж байна.

Бага насны хүүхдүүдэд зориулсан 4 цагийн хичээлээр 4 болон 5 настай хүүхдүүдэд ижил агуулга өгч байгаа ч сэдэлжүүлэлт, үйл ажиллагааны бататгал, сургах тоглоомыг тухайн насны хүүхдийн хөгжлийн онцлогт тохируулан ялгаатай байдлаар боловсруулав. Мөн хичээл тус бүрийн арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн материалыг өөрчлөх (багш өөрөө баяжуулж ч болно)

замаар үндсэн агуулгыг өөрчлөхгүйгээр давтан сургалт зохион байгуулах боломжтой байдлаар боловсруулахад анхаарав. Ингэснээр багш хүүхдүүдийн насны онцлог, анхан болон давтан сургалт эсэхээс хамаарч ямар арга зүй, аргачлалаар сургалтыг хөтлөн явуулахаа өөрөө сонгох боломжтой. Дахин сануулахад, хүүхдэд зориулсан 4 цагийн сургалтыг цуврал байдлаар заасны дараа бага насны хүүхдүүд учирч болох хүчирхийллийн эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэгийг олж авна.

Хичээл тус бүрийн төгсгөлд “Багшид өгөх нэмэлт мэдээлэл” хэсэг байгаа ба тус хэсэгт байгаа заах хичээлийн агуулгыг та бүхэн сургалт зохион байгуулахын өмнө заавал уншиж танилцан, өөрийн болгож эзэмшээрэй. Цаашлаад, хичээл бүрийн төгсгөлд “Нэмэлтээр дэлгэрүүлж унших материал” хэсэгт тус сургалтын модульд багтаагүй бусад нэмэлт гарын авлага, ном сурах бичиг, холбогдох хууль эрх зүйн баримтуудыг жагсаан бичлээ.

Тус сургалтын модульд сургалтад хэрэглэх DVD-г хавсаргасан тул, та бүхэн номоо уншингаа сургалтад хэрэглэх нэмэлт материалууд, жишээ видео хичээлийг үзэж, мэдлэгээ бататгах боломжтой.

Та бүхний заасан сургалт бүрийн дараа нэг хүүхэд, нэг гэр бүлийн амьдралд эерэг өөрчлөлт гарна гэдэгт бид бат итгэлтэй байна. Ингээд та бүхэнд амжилт хүсье.

Сургалтын модуль боловсруулсан баг

НОГООН НОМ

Эцэг эх, асран
хамгаалагчдад
зориулсан
сургалтын агуулга

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтын хөтөлбөр

1:	2:	3:	4:
<p>Хүний эрх ба хүүхдийн эрх</p> <p>/60 минут/</p>	<p>Хүчирхийллийн төрөл, хэлбэрүүд</p> <p>/60 минут/</p>	<p>Хүүхэд хүмүүжүүлэх ээрэг аргууд</p> <p>/60 минут/</p>	<p>Бага насны хүүхдээ хүчирхийллээс хамгаалах арга зүй</p> <p>/60 минут/</p>
<p>“Шинэ гариг руу нүүцгээе!” дасгал</p>	<p>Хүчирхийлэл яагаад үйлддэг вэ? дасгал</p>	<p>“Хорин таван жилийн дараах таны хүүхэд” дасгал</p>	<p>“Цэцэн дүүтэй болсон нь”</p> <hr/> <p>“Никитад тохиолдсон явдал” дасгал</p>
<p>Хүүхдийн эрхийг таньж мэдье дасгал</p>	<p>Ангилья дасгал</p>	<p>“Та ямар тохиолдолд хүүхдэдээ уурладаг вэ?” дасгал</p>	<p>“Гэрийн дүрэмтэй болцгооё” дадлага</p>
<p>Бататгал & дүгнэлт</p>	<p>Бататгал & дүгнэлт</p>	<p>Бататгал & дүгнэлт</p>	<p>Бататгал & дүгнэлт</p>

ХИЧЭЭЛ 1:

ХҮНИЙ ЭРХ БА ХҮҮХДИЙН ЭРХ






Хичээлийн зорилго:

Хүний эрх ба хүүхдийн эрхийн талаар дасгал, хэлэлцүүлэг хийх замаар оролцогчдын хүний эрх болон хүүхдийн эрхийн талаарх суурь ойлголт, мэдлэгтэй болгоно.

Хүлээгдэж байгаа үр дүн:

Хүний эрх, хүүхдийн эрхийн талаар оролцогчид ойлголт, мэдлэгтэй болсон байна.

Хүний эрхийг дээдлэх, хүүхдийн эрхийг зөрчихгүй байх талаар хандлагыг төлөвшүүлэхэд нөлөөлсөн байна.

N°	Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын хэлбэр	Шаардагдах сургалтын материал, хэрэглэгдэхүүн
1	 <p>Сургалтын танилцуулга</p>	2 мин	Чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг	
2	 <p>Үйл ажиллагаа 1: Хүүхдийн эрхийн тухай ойлголт өгөх: “Шинэ гариг руу нүүцгээ!” дасгал</p>	20 мин	Багаар ажиллах дасгал Хэлэлцүүлэг, ярилцлага Бататгал	Эрх, хэрэгцээг, хүсэл 20 карт Самбар, самбарын цаас, самбарын үзэг Ханын скоч
3	 <p>Үйл ажиллагаа 2: Хүүхдийн эрхийг таньж мэдье дасгал</p>	20 мин	Багаар ажиллах даалгавар Чөлөөт хэлэлцүүлэг, ярилцлага	
4	 <p>Бататгал</p>	3 мин	Оролцогчдын санал сэтгэгдэл Хэлэлцүүлэг	Бататгах асуултууд
5	 <p>Дүгнэлт</p>	5 мин	Оролцооны арга	Асуулгын хуудас

ҮЙЛ АЖИЛЛАГАА 1

“ШИНЭ ГАРИГ РУУ НҮҮЦГЭЭЕ”¹

20 минут

Багш, сургалтад оролцож байгаа багш/эцэг эхчүүдийг 4 баг (оролцогчдын тооноос хамааран дөрвөөс их эсвэл цөөн багт хувааж болно) болгон хувааж баг тус бүрд 20 өгүүлбэр бүхий багц карт (сургалтын DVD-с тус багц картыг урьдчилан хэвлэж бэлтгэнэ үү) тарааж өгнө.

- a Багаараа ярилцаад эдгээр өгүүлбэрүүдийг ХЭРЭГЦЭЭ, ХҮСЭЛ, ЭРХ гэсэн 3 бүлэгт хуваан ширээн дээр байрлуулахыг хүснэ. Багууд доорх асуултын хүрээнд ярилцана: “ХЭРЭГЦЭЭ”, “ЭРХ”, “ХҮСЭЛ” тус бүрийн онцлог юу вэ? Юугаараа ялгаатай байна вэ?
- b Яагаад зарим “хэрэгцээг” эрх хэмээн хамгаалсан байна вэ?
- c Бүх хүүхэд эдгээр эрхийг эдэлдэг үү?
- d Та бүхний бодлоор хүүхдүүдэд өөр ямар эрх хэрэгтэй вэ?

Баг бүр эдгээр асуудлаар саналаа танилцуулахаар бэлдэнэ.

Багш:

Бүгдээрээ шинэ гариг руу нүүх гэж байна гэж төсөөлцгөө. Нэгэнт бүхнийг шинээр эхлэх гэж байгаа тул бидэнд амьдрах, хөгжихөд хэрэгтэй бүх зүйлээ авч явахад бэлтгэе!

- o Баг бүрд тэмдэглэлийн 4 цаас өгч, 20 картад багтаагүй өөр чухал зүйлээ бичихийг хүснэ. Нэг цаасан дээр нэг л хэрэгцээт зүйл бичихийг анхааруулна. Энэ нь 4 хүртэл чухал зүйл бичих хэрэгтэй гэдгийг харуулна.
- o Багш: “Хөлгийн ахмадаас тушаал ирсэн байна. Бидний авч явах ачаа хэтэрсэн тул хэрэгцээт 24 зүйлээс ердөө 15-г нь авч явах боллоо” гэж хэлнэ. Баг бүр авч явахаар жагсаан бичсэн 24 картаас 9-ийг нь хасна.
- o Багш: “Хэдийгээр бид ачаагаа хөнгөлсөн ч авч явах ачааны даац хэтэрсэн тул ачаагаа дахин хасаж, хамгийн чухал 10 зүйлээ авч явахыг хөлгийн ахмад мэдэгдлээ” гэж хэлнэ. Багууд хоорондоо ярилцан дахин 5 картаа хасна.
- o Эцэст нь баг бүрийн хамгийн чухал гэж авч үлдсэн 10 карт дээр хэлэлцүүлэг өрнүүлэн дараах асуултуудыг асууна:

- a** Хамгийн түрүүнд ямар картыг хасахад амархан байсан бэ? Яагаад?
- b** Хоёрдахь ээлжинд хасалт хийхэд юуг хасахад хэцүү байсан вэ? Яагаад?
- c** “ХҮСЭЛ” болон “ХЭРЭГЦЭЭ” хоёрын ялгаа юу байсан бэ?
- d** Хүн бүрийн хүсэл, хэрэгцээ адил байсан уу ялгаатай байсан уу, эсвэл хэн байхаас үл шалтгаалан нэг л байсан уу?
- e** Яагаад хүүхдэд “хэрэгцээтэй” байгаа зарим зүйлс нь байхгүй байна вэ? Хүүхдүүдэд хэрэгцээтэй байгаа эдгээр зүйлээр хангахад бид юу хийж чадах вэ?

ЭРХ/ХЭРЭГЦЭЭ

Түгээмэл шинжтэй, амин чухал хэрэгцээг хуулиар хамгаалдаг ба үүнийг бид эрх гэж ойлгодог.

ХҮСЭЛ/ ХЭРЭГЦЭЭ

Дулаан, аюулгүй орон гэр

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 27-р зүйл)

Тайлбар:

Хүүхэд нь төрсөн цагаасаа эхлэн бие махбодын, оюун санааны, итгэл үнэмшлийн, ёс суртахууны, нийгмийн хувьд хөгжих боломж бүхий орчинд амьдрах ёстой. Засгийн газар уг нөхцөлийг бүрдүүлж чадаагүй гэр бүлд туслах үүрэгтэй яагаад гэвэл энэ конвенц-д нэгдсэн улс орнуудын Засгийн газар үүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Эцэг эх/асран хамгаалагчид хүүхдийг эрүүл өсгөхөд шаардлагатай аюулгүй орон байраар хангах үүрэг хүлээдэг.

Сүүлийн үеийн загварын хувцас

Эрүүл байх, эрүүл мэндийн нөхөн сэргээх, өвчнийг эмчлэх нөхцөл бололцоогоор хангагдах

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 24-р зүйл)

Тайлбар:

Чанартай эрүүл мэндийн үйлчилгээ авах (эм тариа, эмнэлэг, эрүүл мэндийн мэргэжилтэн гэх мэт). Жишээ нь, Засгийн газар 18 хүртэл насны хүүхдийн эрүүл мэндийн даатгалыг хариуцдаг, ба хүүхдэд үнэ төлбөргүй эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. Ийм учир хууль эрх зүйн баримт бичигт энэ асуудлыг тусгаж өгсөн байдаг

Эцэг эх/асран хамгаалагчдад хүүхдийг төрсөн цагаас нь эхэлж шаардлагатай дархлаажуулалт, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах үүрэг хүлээнэ.

Унадаг дугуй

Үл хайхрах болон хүчирхийллээс хамгаалуулах

(Хүүхдийн эрхийн тухай конвенц 19-р зүйл)

Тайлбар:

Хүүхэд хүчирхийлэлд өртвөл хүүхдийг төр хамгаалалтандаа авах үүрэг хүлээдэг. Жишээ нь, гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдийг хүчирхийлж, амь насанд нь аюул учруулах, үл хайхарч байвал төр хүүхдийг гэр бүлээс тусгаарлах, амь насыг хамгаалах үүрэг хүлээдэг. Түүнчлэн, хүүхэдтэй зүй бусаар харьцах, үл ойшоох явдлаас хамгаалахыг баталгаажуулна.

Эцэг эх/асран хамгаалагчид нь хүүхдийг үл хайхарч, хүчирхийлэхгүй байх, аливаа хүчирхийллээс хүүхдийг хамгаалах- хүүхэд хүмүүжлийн эерэг арга хэрэглэх үүрэг хүлээнэ.

Аяллын хэрэгслүүд

Боловсрол

(Хүүхдийн эрхийн тухай конвенц 28, 29-р зүйл)

Тайлбар:

Засгийн газар нь хүүхэд суралцах чанартай барилга байгууламж, сургалтын тоног төхөөрөмж хэрэгслээр хангаж, сурагчдад чанартай боловсрол олгох үүрэг хүлээнэ.

Эцэг эх/асран хамгаалагчид хүүхдээ сургуульд сургах үүрэгтэй ба үүнд хүүхдийнхээ сургууль/цэцэрлэгийн үйл ажиллагаанд оролцох, шаардлагатай хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах үүрэг хүлээдэг.

Хувийн өрөө

Ялгаварлалгүй, тэгш хандах

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 2-р зүйл)

Тайлбар:

Үл ялгаварлах гэдгийг хүн бүрт тэгш хандаж, хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлийг хангах гэж ойлгох ба төр нь хүүхдийг аливаа ялгаатай байдлаасаа үүдэн (хүйс, эрүүл мэндийн байдал, шашин шүтлэг, угсааны цөөнх гэх мэт) ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах үүрэг хүлээдэг.

Эцэг эх/асран хамгаалагчид нь хүүхдээ ялгаварлан гадуурхахгүй хамгаалах үүрэгтэй (жишээ нь эрэгтэй хүүхдээ сургуулиас гаргаж малчин болгоод, эмэгтэй хүүхдээ дээд сургуульд сургах гэх зэргээр ялгаварлаж болохгүй) байх, ялгаварлан гадуурхагдахаас хамгаалах үүрэгтэй.

Телевиз, хувийн компьютер

Цэвэр агаар

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 24-р зүйл)

Тайлбар:

Төр нь хүрээлэн буй орчны бохирдох эрсдэл, аюулыг анхааралдаа авах, хүүхэд эрүүл аюулгүй орчинд эсэн мэнд амьдрах эрхийг хангах үүрэгтэй.

Эцэг эх/асран хамгаалагчид нь хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн хэрэгжилтийг хангахыг төрөөс шаардаж болно.

Хувийн стерео хөгжим

Үзэл бодлоо илэрхийлэх

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 12-р зүйл)

Тайлбар:

Хүүхдэд хамаарах шийдвэрийг насанд хүрсэн хүмүүс гаргах үед хүүхэд өөрийн юу бодож байгааг чөлөөтэй хэлэх өөрийн байр суурьд анхаарлыг хандуулах эрхтэй байдаг. Засгийн Газар нь хүүхдийг эвлэлдэн нэгдэх, дуу хоолойгоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх үүрэг хүлээдэг.

Эцэг эх/асран хамгаалагчид нь хүүхэдтэй хамааралтай асуудлаар шийдвэр гаргахдаа (тухайлбал, өөр сургууль руу шилжүүлэхдээ хүүхдээс саналыг нь асуух) хүүхдийн саналыг сонгох боломжоор хангана.

Өөрийн хүссэнээр хэрэглэх мөнгө

Тоглож, наадах

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 31-р зүйл)

Тайлбар:

Засгийн газар хүүхдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, насныхаа онцлогт тохирсон тоглоом наадамд оролцох, соёлын амьдрал, урлан бүтээх үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулна.

Эцэг эх/асран хамгаалагчид нь хүүхэд амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, өөрийн насны онцлогт тохирсон тоглоомоор тоглох эрхтэйг хүлээн зөвшөөрч, аюулгүй тоглох орчин нөхцөл боломжоор хангах, цаг гарган хамт тоглох гэх мэтээр энэ эрхийг хангана.

Бургер, кока кола гэх мэт түргэн хоол

Цэвэр ус

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 24-р зүйл)

Тайлбар:

Төр нь ариун цэврийн тусламжийн хүрээнд ундны цэвэр усаар хангах үүрэгтэй

Эцэг эх/асран хамгаалагчид нь цэвэр ундны ус хэрэглэх, хүүхдийн цэвэр ундны усаар хангагдах эрх хангагдаж байгаа эсэхэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд төрөөс энэ эрхээ эдлүүлэхийг шаардаж болно.

Төрөлх хэл, соёл, шашнаа сурах, шүтэх

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 30-р зүйл)

Тайлбар:

Тухайн улсынхаа иргэний хувьд хүмүүстэй адил эсэхээс үл хамааран, өөрийн гэр бүлийн уламжлал, шашин, хэлийг сурах, хэрэглэх эрхтэйг хамгаалах, хангах үүрэг хүлээнэ

Эцэг эх/асран хамгаалагчид нь хүүхдийнхээ төрөлх хэлээр ярих, соёл зан заншлаас суралцах боломжоор хангах, хүүхдийнхээ шашин шүтэх, эс шүтэх эрхийг хүндэтгэх үүрэгтэй.

Тэжээллэг хоол хүнс

(Хүүхдийн эрхийн тухай конвенц: 34-р зүйл)

Тайлбар:

Төр нь хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, хөхөөр хооллохын давуу тал, эрүүл ахуй, амьдрах орчны ариун цэвэр, осол аюулаас урьдчилан сэргийлэх талаарх мэдээллээр нийгмийн бүх давхарга ялангуяа эцэг эх, хүүхдийг хангах, түүнчлэн энэ чиглэлээр боловсролтой болгох, суурь мэдлэгээ ашиглаж дэмжлэг тусалцаа үзүүлэх үүрэгтэй.

Эцэг эх/асран хамгаалагчид нь чанартай, эрүүл, тэжээллэг хоол хүнсээр хүүхдээ хангах үүрэгтэй.

Дээрх 20 картын 11 нь хүүхдийн эрхтэй холбоотой картууд бөгөөд дараах хүүхдийн 4 багц эрхүүд юм.

Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

Дулаан, аюулгүй орон гэр
Тэжээллэг хоол хүнс
Эрүүл мэндийн үйлчилгээ, асаргаа
Цэвэр агаар
Цэвэр ус

Хөгжих эрх

Боловсрол
Тоглож, наадах
Өөрийн хэл, соёл, шашнаа сурах/шүтэх

Хамгаалуулах эрх

Үл хайхрах болон хүчирхийллээс хамгаалуулах
Ялгаварлалгүй, тэгш хандах

Оролцох эрх

Үзэл бодлоо илэрхийлэх боломж

Багшийн өгөх мэдээлэл:

- Хэрэгцээ бол хариуцлагыг дагуулдаггүй. Харин эрх бол хариуцлагатай хамт олгогдоно. Жишээ нь төр хүний эрхийг хангах болон хамгаалах үүрэгтэй
- Хүний эрх нь ялгаварлалгүй, салшгүй, хуваагдашгүй, харилцан хамааралтай, хүн бүрт түгээмэл, харилцан өөр хоорондоо хамааралтай байдаг
- Хүний эрх гэдэг ойлголт нь хүн болж төрсний хувьд заяагдсан, ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамааран эдэлбэл зохих эрх, эрх чөлөөг хэлдэг. Хүний эрх нь хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ шаардлага, оршихуйн үндэс юм.
- Хүн бүр яс үндэс, арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарал, өмч хөрөнгө, эрүүл мэнд болон бусад байдлаар ялгаваргүйгээр эрхээ эдлэх нь хүний эрхийн хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал юм.

Хүний эрхийн зарчмууд ²	Тайлбар
Салшгүй	Хүний эрх хүн бүрт төрсөн цагаас нь эхлэн үйлчилнэ Хүний эрхийг тухайн хүнээс салгаж ойлгож болохгүй Хүний эрхээс татгалзаж болохгүй
Түгээмэл	Бүх хүн хаана, хэзээ ч адил эрх эдэлнэ (Хүний тодорхой эрхүүдийг хязгаарлах зарим нөхцөл байдал үүсч болно, тухайлбал, шоронд хоригдож байгаа хэрэгтний шилжин явах эрх чөлөө зэрэг)
Хуваагдашгүй буюу харилцан шүтэлцээтэй	Бүх эрхүүд нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд нэг нэгэндээ нөлөөлдөг. Хэрэв нэг эрх зөрчигдвэл энэ нь өөр нэг эрхэд нөлөөлнө. Хэн нэгний эрх хангагдахын тулд бусдын эрх зөрчигдөх ёсгүй

Дүгнэлт:

Хүн бүрийн үнэ цэнэ, нандин чанарыг хүндэтгэхэд хүний бүх эрхүүдийг ижил ач холбогдолтой, адил тэнцүүгээр авч үзэх ёстой.

ҮЙЛ АЖИЛЛАГАА 2

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ТАНИН МЭДЬЕ!

20 минут

Багш

Бид хүний эрхийн талаарх ойлголт мэдлэгээ нэмэгдүүллээ. Одоо хүүхдийн эрхийн талаар ярилцъя. Багшийн тавих асуултууд:

- a Яагаад хүүхдийн эрхийн тухай тусад нь ярих ёстой вэ?
- b Хүүхэд ямар эрхтэй вэ?
- c Эцэг эх ямар үүрэгтэй вэ?
- d Хүүхдийн эрхүүдийг нэрлэнэ үү?
- e Төрийн байгууллага, хүүхдийн эрхийг хангахад ямар үүрэгтэй вэ?
- f Эцэг эх ямар үүрэгтэй вэ?

Асуултуудад хариулт авсны дараа багш хүүхдийн эрхийн талаар илүү сайн нарийн мэдэхийн тулд дасгал ажиллуулна.

Зааварчилгаа

Сургалтад оролцож байгаа багш/эцэг эхчүүдийг 4 баг болгон хувааж, баг тус бүрд хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох үндсэн 4 багц эрхтэй холбоотой өгүүлбэрийг өөр өөр өнгийн цаасан дээр бичиж, оролцогчдод тарааж өгнө. (Тарааж өгөх материалыг багшийн өгөх нэмэлт хэсгээс авна). 4 тусдаа байршилд хүүхдийн 4 багц эрхийг бичиж тавьсан байна. Багийн ажил дууссаны дараа баг бүрээс нэг оролцогч гарч, яагаад тухайн асуудал хүүхдийн тухайн эрхтэйг холбоотойг тайлбарлахыг хүснэ. Үүний дараа багш багийн ажлуудыг нэгтгэн дүгнэнэ. (Багш нар өөрсдөө цэцэрлэгийн орчин хүүхдийн эрхийн асуудлуудыг хөндсөн жишээ баримтуудыг кейс болгон ажиллуулах нь илүү тохиромжтой)

Тараах материалын жишээг харна уу:

Нэгдүгээр баг: Ахуйн осолд 2017 онд 298 хүүхэд өртжээ. Хүүхдүүд ахуйн осолд нэрвэгдэж гэмтэх, амь насаа алдах явдал их байгаа ба хүүхдийн ахуйн ослоор нас баралтын 21% нь зам тээврийн осол, 16% нь түлэгдэлт, 14% нь усанд живэх, 17% нь хордолт, 32% нь юмнаас унах болон бусад шалтгаантай байна. Тухайлбал, ГССҮТ-ийн 2016 оны мэдээгээр 5 хүртэлх насны хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралт хүүхдийн нийт нас баралтын 14.4%-ийг эзэлж байгаа бөгөөд түүний 76.5% нь түлэгдэлтийн, үүнээс 77% нь халуун хоол, цайнд, 23% нь халуун усанд түлэгдсэн байна. 214 ГССҮТ-ийн түлэнхий, нөхөн сэргээх мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдийн 80% нь бага насны хүүхэд байна. 215 Осол гарах болсон шалтгааны 89.3% нь эцэг эхийн хараа хяналт сулаас, 10.7% нь анхаарал болгоомжгүй байдлаас болсон гэж тогтоожээ.

Хөндөгдөж буй хүүхдийн эрх: - Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, Хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл

Хоёрдугаар баг: Бага насны 3 охиныг ээж аав нь хүнд хүчир ажил хийлгэн мөнгө олуулж, олсон мөнгөөр нь архи уудаг байжээ. Түүгээр барахгүй тэд охиныг тоглохоор явахад нь араас нь очиж зодож, гэртээ авчирдаг байв. Эцэг эх тасралтгүй архи ууж, охиноо хүчирхийлсээр байсан тул, 3 охиныг хүүхдийн асрамжийн газарт шилжүүлжээ. Ээж аав нь архинд ороогүй байсан бол 3 охин аз жаргалтай элэг бүтэн амьдарч байх байсан."

Хөндөгдөж буй хүүхдийн эрх: -Хүүхдийн хамгаалуулах эрх: гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, хүүхдийг үл хайхрах хүчирхийлэл, хүүхдийн хөгжих эрх

Гуравдугаар баг: Бага насандаа хүүхэд СӨБ-д хамрагдахгүй, мөн зохих орчинд чанартай боловсрол эзэмшиж чадахгүй байгаа нь хүүхэд бага ангиасаа эхлэн хичээлээс хоцрох, улмаар сургууль завсардах ч эрсдэлийг бий болгож байна.

Хөндөгдөж буй хүүхдийн эрх: хүүхдийн хөгжих эрх, боловсрол эзэмших эрх

Дөрөвдүгээр баг: А сумын хүүхдүүд өөрсдөө санаачлан "Өсвөрийн сурвалжлагч" нэртэй клуб байгуулжээ. Клуб нь сумынхаа хүүхдүүдийн хийж байгаа сайн үйлсийг бусад хүүхдүүдэд танилцуулж, мэдээллийн хуудас гаргах болжээ. Гэтэл сургуулийн захиргаанаас хүүхдүүдийн энэхүү санаачилгыг сул анги танхим байхгүй гэсэн нэрийдлээр дэмжихээс татгалзав.

Хөндөгдөж буй хүүхдийн эрх: Нийгмийн амьдралд оролцох эрх

Багийн гишүүдэд өгөх даалгавар:

Тарааж өгсөн материалыг уншиж, хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх, хөгжих эрх, хамгаалуулах эрх, нийгмийн амьдралд оролцох эрх вэ гэдэг талаар баг хоорондоо ярилцаад ярилцаж, зөв гэж бодож байгаа эрхийн доор өгүүлбэрүүдийг байрлуулна. Баг бүрээс нэг гишүүн гарч танилцуулга хийнэ.

Дүгнэлт:

Сургалтад оролцогчдоос үзсэн хичээлээ бататган: хүний эрх, хүүхдийн 4 багц эрхийн талаар ямар зүйлийг шинээр мэдсэн. Түүнийг хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчид ямар үүрэгтэй болохыг асууж бататгана. Хүүхдийн эрхийн тухай яагаад тусгайлан ярих ёстой. Эрх нь яагаад хуваагдашгүй, түгээмэл, харилцан хамааралтай байдаг талаар мэдлэгийг бататгана.

Хичээлийн төгсгөлд дараах асуулгын хуудас бөWглүүлж авна!

Хичээл 1. Хүний эрх ба хүүхдийн эрхийн хичээлийн агуулгаар оролцогчдын мэдлэгийг тандах асуулга (хичээлийн өмнө хойно авч мэдлэгт гарсан өөрчлөлтийг хэмжинэ)

Асуулга

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая!

Та дараах асуултуудад хариулж бидний ажилд гүн туслалцаа үзүүлнэ үү. Та асуултыг анхааралтай уншаад зөв гэж бодож байгаа асуултыг дугуйлан тэмдэглэнэ үү.

1. Хүний эрхийн асуудал нь зөвхөн Монгол улсад амьдардаг хүмүүст хамаатай. Манай улсад амьдардаггүй хүмүүст хүний эрхийн асуудлууд хамаарахгүй

Үнэн Худал

2. Хүний эрхийг дагаж хариуцлага ирдэг

Үнэн Худал

3. Хэрэгцээ хуулиар хамгаалагдана

Үнэн Худал

4. Хүний эрх нь зөвхөн хүчирхийллээс ангид байх эрх юм

Үнэн Худал

5. Хүүхдийн эрх хуулийн хамгаалалтад байдаг

Үнэн Худал

6. Хүүхэд эсэн мэнд амьдрах, оролцох, хамгаалуулах, тоглох гэсэн үндсэн эрхтэй

Үнэн Худал

7. Хүүхдээ сургуульд явуулах эсэхийг эцэг эх шийднэ.

Үнэн Худал

8. Хүүхэд төрмөгц эцэг эх хүүхдээ нэр өгөх, бүртгүүлэх үүрэгтэй

Үнэн Худал

9. Хүүхэд бүр суурь боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхтэй

Үнэн Худал

ТАНД ИХ БАЯРЛАЛАА

Багшийн өгөх нэмэлт мэдээлэл:

- Хүүхэд бүр төрсөн цагаасаа эхлэн хүний язгуур эрх, эрх чөлөөг эдлэх ёстой. Энэ бол дэлхийн хүүхэд багачууд болон тэдний гэр бүлийн сайн сайхан амьдралыг баталгаажуулсан олон улсын хүний эрхийн баримт бичиг болох Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн үндсэн зарчим юм. 1989 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг соёрхож баталсан билээ. Монгол Улс уг Конвенцид 1990 онд нэгдэн орж, түүнийг хүлээн зөвшөөрсөн дэлхийн 5 дахь орон болсон юм.
- Хүүхдийн эрх хуулиар хамгаалагдаж байхыг шаарддаг учир Монгол улс Хүүхдийн эрхийн тухай хууль (Энэ хууль нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.), Хүүхэд хамгааллын тухай хуулийг (Энэ хууль нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг) 2016 онд батлан хэрэгжүүлж байна.
- Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай байдаг учир хүүхдийн эрхийг тусгайлан авч үздэг
Хүүхэд бол эцэг эхийн өмч биш. Зөвхөн тусламж дэмжлэг авагч биш

Хүүхэд бол:

- Бусдын адил хүн, гэр бүл, олон нийтийн бие даасан гишүүн, гэр бүл, олон нийтийн бие даасан гишүүн, насандаа тохирсон эрх, үүрэг бүхий хувь хүн, эрх эдлэгч
- **Хүүхдийн эрхийг:** эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох гэж ангилдаг хэдий ч хүний эрхийн адил хуваагдашгүй, салшгүй. Хүүхдэд олгож буй тусгай эрх биш харин хүн бүрт тэр дундаа хүүхдэд төрөлхөөс заяагдмал үндсэн эрх юм.
- Хүүхдийн эрхийг хангах нь сонголтоор хийх зүйл биш, эсвэл сайхан сэтгэл, сайн санааны үүднээс хийх зүйл биш. Харин энэ нь бүх нийтээр хүндэтгэн дагах ёстой үүрэг хариуцлага мөн.

Хүүхдийн эрх:

Хүүхэд бүр ямар ч алагчлалгүйгээр: хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ хүртэж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж, бие хүн болж төлөвших, авьяас, чадвараа бүрэн дүүрэн нээн хөгжүүлэх боломжоор хангагдаж, аз жаргал, хайр энэрэл, ойлголцол бүрдсэн орчинд өсөн торниж, өөрсдийн эрхийн талаар мэдлэг, мэдээлэлтэй байж, эрхээ эдлэх үйл явцдаа идэвхтэй оролцох боломжтой

Хүүхдийн эрхийн зөрчил байгаа учир өнөөдөр хүүхдийн эрхийн тухай ярих, энэ талаар эцэг эхчүүдийн ойлголтыг нэмэгдүүлэх шаардлагатай. Хүүхдийн эрхийн зөрчлүүд:

- Хүүхэд ядууралд өртөж байна.
- Хүүхэд хөдөлмөр эрхэлж байна.
- Хүүхэд хараа хяналтгүй болж байна
- Хүүхэд осол гэмтэл, халдлагад өртөж байна
- Хүүхэд хүчирхийлэлд өртөж байна.
- Хүүхэд сургууль завсардаж байна зэрэг

Хүүхдийн эрхийг хамгаалах, зохицуулах хууль эрх зүйн баримт бичиг

- Хүүхдийн эрхийн конвенц
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль

Хүүхдийн үүрэг

- ЭРХЭЭ МЭДДЭГ БАЙХ
- ӨӨРИЙГӨӨ ХАМГААЛАХ ЧАДВАРТАЙ БАЙХ
- ОРОЛЦОХ-ХӨГЖИХ

Хүүхдийн эрхийг хангахад эцэг эх ямар үүрэгтэй вэ? гэдгийг **ЭРХ, ХҮСЭЛ, ХЭРЭГЦЭЭ** 20 карт дээр ажиллах үед тайлбарлан танилцуулж болно

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх:

1

Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх	Эцэг эх, асран хамгаалагчдын хүлээх үүрэг	Төрийн институцийн үүрэг
Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх	Нэр өгөх, бүртгүүлэх, төрсний гэрчилгээ авах	Сум, дүүргийн ЗДТГ-ын иргэний бүртгэл мэдээллийн хэлтэс
Хүүхэд эрүүл өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх	Нас, сэтгэцийн онцлогт тохирсон хүмүүжлийн эерэг аргуудаас хэрэглэх Аливаа осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлгүй тайван орчин, харилцааг бүрдүүлэх	Хороо, багийн Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ, Хамтарсан багийн хариу үйлчилгээ
Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжинд байх, тусдаа амьдрах үеийн хүүхдийн хамгаалал, оролцоо	Гэр бүлийн тогтвортой эерэг харилцааг бий болгох, хайр халамж үзүүлэх	Хороо, багийн Хамтарсан багийн урьдчилан сэргийлэх үйлчилгээ, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, шүүх
Эмнэлэг, тэтгэмж, асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ авах	Үйлчилгээнд хамруулах мэдлэгтэй байх	Холбох институцийн хариуцсан албан тушаалтан үүрэг хүлээнэ
	Хүүхэдтэйгээ хамт байх эрх зүйн мэдлэгтэй байх	Гадаадын иргэн харьяатын алба, эрх зүйн чадамж бүхий гэрээ, элчин сайдын яамд хүүхдийн энэ эрхийг хангах үүрэг хүлээнэ.

Хүүхдийн хөгжих эрх:

2

Хүүхдийн хөгжих эрх	Эцэг эх, асран хамгаалагчдын хүлээх үүрэг	Төрийн институцийн үүрэг
Бага, дунд, суурь боловсролыг үнэ төлбөргүй эзэмших	Сургуульд бүртгүүлэх, хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцас, бусад хэрэгцээг зүйлээр хангах, дэмжих	Хамран сургах тойргийн сургууль, цэцэрлэг
Төрөлх хэл, бичиг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших	Гэр бүлийн уламжлалаа өвлүүлэх	Бүх шатны боловсролын байгууллагууд энэ эрхээ эдлэхэд нь үүрэг хүлээнэ
Оюун ухаан, авьяас билэг, бие бялдараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах	Мэдлэг, хандлага төлөвшүүлэх, эрэл хайгуул хийхэд нь дэмжлэг үзүүлэх	Сургууль, цэцэрлэг нь холбогдох байгууллагуудад холбон зуучлах, нийгмийн ажилтан хүүхдийн оролцоо, авьяасыг нээн илрүүлэх, дэмжлэг үзүүлэх
Шашин шүтэх, эс шүтэх	Хүүхдээ сонсох, сонголтыг нь хүндэтгэх	Шашны буруу гаж нөлөөний үр дагавар, сөрөг нөлөөг таниулах, хамгаалах
Гэр бүл, нийгмийн орчинд өөрийгөө хөгжүүлэх	Дугуйлан секц, зуслан, сувилалд амрахад нь дэмжлэг үзүүлэх	Хөгжлийн төвүүдэд хамруулах, байгуулах, анги удирдсан багш болон гэр бүлтэй нь хамтран ажиллах

Хүүхдийн хөгжих эрх:

Хүүхдийн хамгаалах эрх	Эцэг эх, асран хамгаалагчдын хүлээх үүрэг	Төрийн институцийн үүрэг
Нийгмийн бүх орчинд хамгаалагдах	Хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, эрсдэлээс хамгаалах, хүмүүжлийн эерэг аргыг ашиглах	Боловсролын байгууллагын орчин болон бусад орчинд хүүхдийн энэ эрхийг ханган баталгаажуулах
Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь хүүхдийн эрх зөрчвөл хуулийн дагуу хариуцлага хүлээх, харилцаагаа сэргээх	Хүүхдийн эрхийг зөрчихгүй байх	Хамтарсан баг, Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газар, төвүүд, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
Өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах	Хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, хүндэтгэх, нас сэтгэцийн онцлогийг харгалзах, хүмүүжлийн эерэг аргыг ашиглан хүүхдээ хүмүүжүүлэх	Боловсролын байгууллагын орчин болон бусад орчинд хүүхдийн энэ эрхийг ханган баталгаажуулах, хамтарсан бага
Эрхээ зөрчигдсөн тохиолдолд өөрөө болон итгэмжит төлөөлөгчөөрөө дамжуулан үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах	Хүүхдээ дэмжих, оролцоог нь хангах, хууль ёсны төлөөлөгч нь болох, өмгөөллийн тусламж авах	Хүн амын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Төрийн бус байгууллага Олон улсын байгууллага, шүүх, прокурор, цагдаа, нийгмийн ажилтан

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх:

Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх	Эцэг эх, асран хамгаалагчдын хүлээх үүрэг	Төрийн институцийн үүрэг
Нас сэтгэцийн онцлогт тохирсон хуулиар хориглоогүй арга хэмжээнд оролцох, эвлэлдэн нэгдэх	Дэмжих, туслах, сонсох, шийдвэр гаргах	сургууль, цэцэрлэг, хүүхдийн эрхийн ажилтан, гэр бүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, нийгмийн ажилтан нар энэ эрхийг баталгаажуулахад үүрэг хүлээнэ
Өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөх	Дэмжин туслах	сургууль, цэцэрлэг, хүүхдийн эрхийн ажилтан, гэр бүл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага, нийгмийн ажилтан, засаг дарга, ажил олгогч, нотариат, цагдаа, прокурор, шүүх, Оюуны өмчийн газар
Өөрийн бүтээсэн зохиогчийн эрх, шинэ бүтээл, оновчтой саналыг хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, түүний үр шимийг хүртэх	Дэмжин туслах	засаг дарга, ажил олгогч, нотариат, цагдаа, прокурор, шүүх, Оюуны өмчийн газар
Өөрт ногдох эд хөрөнгийг өмчлөх, өвлөх, ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах холбогдох байгууллагад гомдол гаргах	Хуваарьт өмчийг өгөх, дэмжлэг үзүүлэх	итгэмжлэгдсэн төлөөлөгч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан
Эрхээ эдлэх шаардлага	Дэмжих туслах	итгэмжлэгдсэн төлөөлөгч, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан

Нэмэлтээр дэлгэрүүлж унших материалууд:

НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенц, 1989 он

Боловсролын тухай хууль, 2002 он

Бага, дунд боловсролын тухай хууль, 2002 он

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2002 оны 230-р тушаал:
"Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм"

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2007 оны 41-р тушаал:
"Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм"

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008 он

Зөрчлийн тухай хууль, 2015 он

Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016 он

Хүүхэд хамгааллын тухай хууль, 2016 он

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он

ХИЧЭЭЛ 2:

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ







Хичээлийн зорилго:

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн мөн чанар, төрөл, хүүхдэд үзүүлэх хор нөлөө, уршгийг дасгал ажил, сургамжит түүх танилцуулах замаар оролцогчдын хүчирхийллийн талаар суурь ойлголт, мэдлэгтэй болгоно.

Хүлээгдэж байгаа үр дүн:

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн мөн чанарыг ойлгож, таньж мэдэхийн хамт хор уршгийг мэддэг болсон байна

Хүүхдээ хүчирхийллээс хамгаалах эрмэлзэл, хандлагыг бий болгоход нөлөөлсөн байна

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын хэлбэр	Шаардагдах сургалтын материал, хэрэглэгдэхүүн
1	 <p>Хичээлийн танилцуулга</p>	2 мин	Чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг	
2	 <p>Идэвхжүүлэх дасгал</p>	3 мин	Дасгал	Зааварчилгаа
3	 <p>Үйл ажиллагаа 1: Хүчирхийлэл яагаад үйлддэг вэ?</p>	23 мин	Багаар ажиллах даалгавар Чөлөөт хэлэлцүүлэг, ярилцлага	Самбарын цаас, үзэг
4	 <p>Үйл ажиллагаа 2: Ангилья дасгал: Хүчирхийллийн төрөл хэлбэрүүд, хүүхдэд үзүүлэх хор уршиг</p>	20 мин	Багаар ажиллах даалгавар Чөлөөт хэлэлцүүлэг, ярилцлага	Багц картууд Илтгэл
5	 <p>Бататгах дасгал</p>	15 мин	Багаар ажиллах	Сургамжит түүх Бататгах асуултууд
6	 <p>Дүгнэлт</p>	5 мин	Оролцооны арга	Асуулгын хуудас

Идэвхжүүлэх дасгал

3 минут

А Бүх оролцогчийг нэг тойрог болж шил шилээ харан зогсохыг хүснэ.

Б Дараа нь урдаа болон ардаа зогсож байгаа оролцогчтой аль болох ойрхон зогсоод, доошоо нэг зэрэг явган суухыг хүснэ.

Хэрэв бүх оролцогч хангалттай ойрхон зогссон бол хүн бүр өөрийнхөө ар талд байгаа оролцогчийнхоо өвдөг дээр суусан байна. Тойрогт буй бүх оролцогчид өмнөх оролцогчоо өөрийнхөө өвдөг дээр суулган, нэг ч оролцогч газар суухгүйгээр суусан байна.

В Дараа нь оролцогчдын дундаас нэг хүнийг татаж босгох ба энэ үед бүх оролцогчид тэнцвэрээ алдан унахад хүрнэ.

Энэ дасгалыг хийж дууссаны дараа багш оролцогчдоос дараах асуултыг асууна:

- а Бүх оролцогчид хамтран ажиллаж, нэг ч хүнийг газар суулгахгүй байх энэ дасгалаас юу ойлгосон бэ?
- б Нэг оролцогчийг тойргоос татаж босгоход юу болсон бэ? Энэ үед та бүхэнд юу мэдрэгдэж, ямар сэтгэгдэл төрсөн бэ?
- с Хэрэв тойрогт байгаа хүн бүрийг хүүхдийн эрх гэж зүйрлэвэл, нэг эрх зөрчигдөхөд (нэг хүнийг татаж гаргахад) бусад эрхүүдэд хэрхэн нөлөөлж байна вэ? Нэг эрхийг салангид авч үзэх боломж байна уу?

ҮЙЛ АЖИЛЛАГАА 1: “МИНИЙ ШИЙДЭЛ” ДҮРИЙН ТОГЛОЛТ

23 минут

Хичээлийн зорилго:

Оролцогчдыг хүчирхийллийн мөн чанар, төрөл хэлбэрийг таньж мэдэх чадварт сургах, хүчирхийллийн илрэх шинж тэмдэг болон хүүхдэд үзүүлэх хор нөлөөний талаар мэдлэгтэй болгох, хүүхдээ хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга ухаанд сургах

Хэрэглэгдэхүүн:

Хүчирхийллийн мөн чанарыг таньж мэдэхэд зориулсан кейсүүд

Хүчирхийллийн төрөл, хэлбэрүүд, илрэх шинж тэмдэг, хүүхдэд үзүүлэх хор нөлөөг танилцуулах танилцуулга

Хүчирхийллийн төрөл, хэлбэрүүдийг харуулсан “Сургамжит түүх”-ээс сонгон уншуулах, ярилцах

Хүчирхийллийн мөн чанарыг таниулах "МИНИЙ ШИЙДЭЛ" дүрийн ТОГЛОЛТ:

Багш нийт оролцогчдыг 4 багт хуваан дараах даалгавар өгнө:

Даалгавар 1

- Таныг ажлаас тарж ирэхэд хүүхдүүд тань гэр орноо буулгаад, таныг юмаа хураа гэхэд огт сонсоогүй мэт үргэлжлүүлэн нураасаар байна. Та энэ тохиолдолд хүүхдээ энэ үйлдийг болиулахын тулд ямар үйлдэл хийх вэ? /Шийдэл: Багийнхан хүүхдээ зодож шийтгэх аргаар асуудлыг шийдэж байгааг харуулна./

Даалгавар 3

- Таныг орой ажлаас ирэхэд 5 настай хүү ээжийнхээ утсаар тоглож байна. Хоолны цаг болж, утсаа болиод хоолоо ид гэхэд хүү үргэлжлүүлэн утсаар тоглосоор байна. Та 2-3 удаа хоолоо ид гэж хэлнэ. Утсаа өгөхгүй, хоол идэхдээ хүртэл утсаар тоглосон хэвээр байна. / Шийдэл:Хүүхдээсээ утсыг булаан авч, хүүхэд уйлна, хоолоо идэхгүй. Эхнэр нөхөр 2 үүнээс болж ам муруйна/

Даалгавар 2

- Таныг цэцэрлэгээс хүүхдээ авах гээд очиход багш нь танай хүүхдийг айлын хүүхэд маажсан, багшийгаа битгий гэхэд үгэнд нь ороогүй байна. Багш таныг хүүхдэдээ энэ асуудлыг ойлгуулаарай гэж хэлнэ. Та гэртээ очоод хүүхдээ яах вэ? /Шийдэл: Багийнхан хүүхдэдээ тайлбарлан ойлгуулах аргаар асуудлыг хүүхдэдээ ойлгуулна.

Даалгавар 4

- Цэцэрлэгт явах цаг болжээ. 4 настай охин босохгүй нойрмоглоно. Та ажилдаа хоцрох гээд байдаг. Охин босдоггүй. Энэ тохиолдолд охиноо цэцэрлэгт нь цагт нь хүргэх болон ажилдаа хоцрохгүйн тулд та ямар үйлдэл хийх вэ? /Шууд: Охиноо шууд босгоод л уйлуулаад аваад гарна./

Даалгавар гүйцэтгэх хугацаа баг тус бүр 5 минут.

Бусад оролцогчдод танилцуулах хугацаа баг бүр 3 минут

Багшийн өгөх

МЭДЭЭЛЭЛ:

Багш дүрийн тоглолт дууссаны дараа тухайн асуудлыг ямар аргаар шийдсэн байдалд дүгнэлт хийж ярилцана. Хүчирхийллийн бус аргаар шийдэх боломж байсныг асуун ярилцана.

А

Хэн нэгэн этгээд өөрийн хүч, эрх мэдэл, давуу байдлаа ашиглан хүүхдийн эрх, эрх чөлөө зөрчсөн, гэм хохирол үзүүлсэн, эсвэл учруулахаар завдсан, түүнийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж үзнэ.

Б

Архидалт, гэр бүлийн доторх хэрүүл, маргаан гэх мэт асуудлууд хүчирхийллийн үр дагавар. Гэр бүлдээ архи уугаад агсам тавьж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь архи нь биш архи уусан хүн өөрийн эрх мэдлийн давуу байдлаа ашиглаж хүчирхийлэл үйлдэж байгаа гэж ойлгоно.

В

Хүүхдийн эсрэг дарамт хүчирхийлэл нь бэлгийн, бие махбодын, сэтгэл санааны зэрэг хэлбэртэй байна. Аливаа нэг субъект өмнөө тулгарсан зорилгодоо хүрэхийн тулд албадлага, хүч хэрэглэх аргыг хэрэглэхийг хэлнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГАА 2: “АНГИЛЪЯ”

20 минут

Үйл ажиллагааны гол зорилго нь хүчирхийллийн хэлбэрүүдийг таньж мэдэх, түүнээс хүүхдэд учрах хор хохирлын талаар мэдлэгээ нэмэгдүүлэх.

Зааварчилгаа

Нийт оролцогчдыг 4 баг болгон хуваана.

1-р багт:

Бие махбодийн хүчирхийлэл

2-р багт:

Бэлгийн хүчирхийлэл

3-р багт:

Сэтгэл санааны хүчирхийлэл
Үл хайхрах хүчирхийлэл гэсэн нэрийг тус тус оноож өгнө.

4-р багт:

Энэ үед ширээн дээр хүчирхийллийн хэлбэрүүд, илрэх шинж тэмдэг, хүүхдэд үзүүлэх нөлөөг бичсэн картуудыг байрлуулсан байна. Картууд холилдсон байх ба багууд карт дээрх өгүүлэмжийг уншин, зөв дараалалд оруулж, эвлүүлнэ. Картууд дээр байрлах мэдээллүүд:

Хүчирхийллийн төрөл хэлбэрүүд	Хүүхдэд илрэх шинж тэмдэг	Хүүхдэд үзүүлэх нөлөө
Бие мах бодийн хүчирхийлэл	<p>Хүүхдийг гараараа, эсвэл олс, саваа, гутал, модон халбага зэргээр ороолгох, цохих (зодох, алгадах, цохих); өшиглөх, сэгсрэх, түлхэх, самардах, чимхэх, хазах, үсдэх, чихнээс нь татах, хүүхдийг тухгүй газар (харанхуй өрөө, малын саравч, буланд гарыг нь өргүүлэх гэх мэт) хүчээр хорих, түлэх, зумлах шалзлах, хүчээр халуун ногоо залгиулах, шүдийг нь савангаар угаах зэрэг үйлдлүүд орно³.</p>	<p>Хүүхдийн тархины хөгжилд муугаар нөлөөлж, ингэснээр танин мэдэхүй, хэлний хөгжил болон суралцах чадварт нь муугаар нөлөөлдөг⁵. Цаашлаад бие мах бодийн хувьд хүүхэд насандаа, өсвөр насандаа, насанд хүрээд ч байнга өвдөмтгий болох магадлалтай байдаг⁶. Хүүхэд насандаа бие махбод болон үл хайхрах хүчирхийллийн хохирогч байсан хүмүүс том болоод алерги, астма, рахит, бронхит, цусны даралт ихсэх, ходоодны шархлаатай болох, элэг бүрэн хөгжихгүй байх, дархлалын тогтолцоо нь муу хөгжих зэрэг сөрөг нөлөө үзүүлдэг⁷.</p>
Бэлгийн хүчирхийлэл	<p>Хүүхэдтэй бэлгийн хавьталд орохыг завдах, дарамтлах, хүүхдэд өөрийнхөө бэлэг эрхтэнг ичгүүр сонжуургүйгээр үзүүлэх/харуулах, хүүхдэд порно кино/дүрс бичлэг/ зураг үзүүлэх, хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох, хүүхдийн бэлэг эрхтэн болон хувийн бүсэд хүрэх, хүүхдийн бэлэг эрхтэнд хүрэхгүйгээр харах, хүүхдийг порно кино/бичлэг/зураг авалтад оруулах, хүүхдийг секс үйлчилгээнд ашиглах зэрэг орно⁸.</p>	<p>Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүд өөрийгөө буруутгах, еертөө итгэлгүй болох, хар дарж зүүдлэх, нойргүйдэх, ой санамжаа түр алдах, өөртөө итгэлгүй болох, өөрийгөө гэмтээх, амиа хорлох сэдэлтэй болох, архаг өвчтэй болох, том болоод бэлгийн хавьталд ороход хүндрэлтэй болох, ХДХВ/ДОХ/БЗДХалдвар авах, түр зуурын зан үйлийн эмгэг, зожиг болох зэрэг нөлөө үзүүлдэг байна¹⁰.</p>

3 Pinheiro, Paulo Sérgio (2006). "Violence against children in the home and family" (PDF). World Report on Violence Against Children. Geneva, Switzerland: United Nations Secretary-General's Study on Violence Against Children. ISBN 92-95057-51-1.

4 What Is Child Abuse and Neglect? Recognizing the Signs and Symptoms 2013, page#6

5 Tiffany Watts-English T, Fortson BL, Gibler N, Hooper SR, De Bellis MD Journal of Social Issues 2006 Volume 62, Issue 4, pages

6 Dolezal, T.; McCollum, D.; Callahan, M. (2009). Hidden Costs in Health Care: The Economic Impact of Violence and Abuse. Academy on Violence and Abuse.

7 Springer KW, Sheridan J, Kuo D, Carnes M (2007). "Long-term physical and mental health consequences of childhood physical abuse: results from a large population-based sample of men and women". Child Abuse Negl. 31 (5): 517–30.

8 Brown, Patricia Leigh (23 May 2011). "In Oakland, Redefining Sex Trade Workers as Abuse Victims". The New York Times. Retrieved 24 May 2011. Once viewed as criminals and dispatched to juvenile centers, where treatment was rare, sexually exploited youths are increasingly seen as victims of child abuse, with a new focus on early intervention and counseling.

9 What Is Child Abuse and Neglect? Recognizing the Signs and Symptoms 2013, page#6

10 Dinwiddie S, Heath AC, Dunne MP, Bucholz KK, Madden PA, Slutske WS, Bierut LJ, Statham DB, Martin NG (2000). "Early sexual abuse and lifetime psychopathology: a co-twin-control study". Psychological Medicine. 30 (1): 41–52. PMID 10722174. doi:10.1017/S0033291799001373.

Хүчирхийллийн төрөл хэлбэрүүд	Хүүхдэд илрэх шинж тэмдэг	Хүүхдэд үзүүлэх нөлөө	
<p>Сэтгэл санааны хүчирхийлэл</p>	<p>Хүүхэд рүү чанга дуугаар орилж хашхирах, хараах, бүдүүлэг зан гаргах, тоохгүй байх, хатуу шүүмжлэх, хүүхдийн нэр төрийг гутаах/гүжирдэх¹¹, нэр хоч өгөх, элэглэж шоолох, хүүхдийн хувийн эд зүйлийг нь булаан авч устгах/үгүй хийх, тэжээдэг амьтдыг нь алах, хүүхдэд хэтэрхий ахадсан болон тохиромжгүй хүсэлт тавих, харилцан яриаг нь таслах, өдөр тутамдаа нэр хоч өгөн, доромжлох¹².</p>	<p>Хэт шаардсан, эсвэл байнга гомдолсон зан гаргах, хэт түрэмгий болох эсвэл ямар ч идэвхгүй байх, бие махбодын болон сэтгэл зүйн хөгжил үеийнхнээсээ хоцрогдох, амиа хорлохоор завдах, эцэг эхтэйгээ ойр дотнын харилцаа үүсгэхгүй байх, нэг бол том хүн шиг (бусад хүүхдүүдийн ээж аав болох гэх мэт) загнах эсвэл нялх хүүхэд шиг зан гаргана¹³.</p>	<p>Хүүхэд өөртөө итгэлгүй болж, өөрийгөө голж, хөгжлөөрөө хоцрогдоно. Сэтгэл зүйн хохирогч болсон олон хүүхэд хүнд итгэх итгэлгүй болж, нийгмээс тусгаарлагдан, сургууль дээрээ хүнд асуудалтай орооцолдон, хүмүүстэй шинэ харилцаа тогтооход хүндрэлтэй байдаг¹⁴.</p>
<p>Үл хайхрах хүчирхийлэл</p>	<p>Эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдийг хэрэгцээт хоол хүнс, хувцас, орон байр, эрүүл мэндийн асаргаа, зөвлөгөөгөөр хангахгүй байснаас хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан амьдралд хор хөнөөл учруулах үйлдлүүд орно. Хүүхдийг хэвийн өсөж хүмүүжихэд шаардлагатай анхаарал халамж, хайр, асаргаагаар хангахгүй байх, урамшуулж дэмжихгүй байх, шаардлагатай боловсролын үйлчилгээнд хамруулахгүй байх, харах хүнгүй ганцааранг нь үлдээх¹⁵.</p>	<p>Хичээлдээ явахгүй таслах, мөнгө болон хоол гуйх/хулгай хийх, байнга усанд ороогүй бохир заваан хувцастай явах, эвгүй үнэр үнэртэх, хүйтэнд нимгэн хувцастай явах, гэрт нь хүн байхгүй ганцаараа байх гэж ярих, шүдний эмчилгээ/харааны шил/дархлаа сайжруулах эмчилгээ шаардлагатай байгаа нь харагдах¹⁶.</p>	<p>Бие мах бодийн болон сэтгэл зүйн хөгжлөөрөө хоцрогдож, сэтгэцийн эмгэг/мэдрэлийн эмгэгт гэмтэл учирснаас гүйцэтгэл, анхаарал төвлөрөлт, юмыг хурдтай хийх, хэл яриа, ой ухаан болоод нийгмийн ур чадварууд муу хөгждөг¹⁷.</p>

Багуудад энэ даалгаврыг хийхэд нийт **5 минут** өгөх ба баг гишүүд бүгд оролцох байдлаар дасгалыг зохион байгуулна. Багууд картыг эвлүүлж дууссаны дараа зөв дарааллаар байрлуулсан эсэхийг хамтдаа шалгаж, ярилцана. Дараа нь энэ хичээлийг бататгах зорилгоор доорх дасгалыг ажиллана.

- 11 Theoklitou D, Kabitsis N, Kabitsi A (2012). "Physical and emotional abuse of primary school children by teachers". Child Abuse Negl. 36 (1): 64–70
- 12 "Child Abuse". The National Center for Victims of Crime. Archived from the original on 27 July 2011. What Is Child Abuse and Neglect? Recognizing the Signs and Symptoms 2013, page#7
- 14 "Emotional Abuse". American Humane Association. Archived from the original on 22 April 2015. Theoklitou D, Kabitsis N, Kabitsi A (2012). "Physical and emotional abuse of primary school children by teachers". Child Abuse Negl. 36 (1): 64–70
- 15 Theoklitou D, Kabitsis N, Kabitsi A (2012). "Physical and emotional abuse of primary school children by teachers". Child Abuse Negl. 36 (1): 64–70
- 16 What Is Child Abuse and Neglect? Recognizing the Signs and Symptoms 2013, page#7
- 17 "Neurocognitive impacts for children of poverty and neglect". Apa.org. July 2012. Retrieved 24 December 2012.

Бататгах дасгал: Сургамжит түүх

15 минут

Багш:

Оролцогсдыг 3-4 баг болгон хуваана. Баг бүрт Сургамжит түүх номноос нэг өгүүллэгийг уншиж, багаараа хоорондоо дараах асуудлын хүрээнд ярилцахыг хүснэ.

Үүнд:

Тухайн түүхэнд хүчирхийллийн ямар хэлбэрийн тухай гарч байна?

Хүчирхийллийг хэн үйлдэж байна?

Танай хүүхдэд ийм асуудал тохиолдсон бол та хэнээс зөвлөгөө авах вэ?

Хүчирхийлэл хүүхдэд ямар сөрөг нөлөө үзүүлж байна?

Та байсан бол хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд ямар алхам хийх байсан вэ?

Баг тус бүрээс нэг хүнийг урьж, оролцогчдод түүхэд гарсан сургамжит зүйл юу байв, хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд ямар алхам хийх талаар санал бодлоо хуваалцана.

Бататгах дасгалын дүгнэлт:

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүхий л хэлбэрүүд нь гэмт хэрэг бөгөөд ойрын ялангуяа хожмын асар их хор уршигтай. Бие мах бодь, эрүүл мэнд, сэтгэл зүй, зан үйлд сөрөг нөлөө үзүүлдэг. Хүүхэд бие махбодийн хүчирхийлэлд өртөх үедээ давхар сэтгэл санаа, эрүүл мэндийн хохирол амсаж байдаг.

Хүүхдийн болчимгүй үйлдлийг хязгаарлах хамгийн хялбар бөгөөд бидний сурсан арга бол “яс маханд нь мэдрүүлэх” буюу бие махбодын болон сэтгэл санааны шийтгэлийг хэрэглэдэг. Гэтэл эдгээр шийтгэлийг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж үзээд хуулиар хориглосон.

Хүүхэдтэй харилцахдаа насны онцлогт тохируулан, асуудлыг ойлгуулах, тайлбарлан, өөрийн эрх мэдлийн давуу байдлыг хүүхэд дээрээ хэрэглэхгүй байх нь хүчирхийлэлгүй ирээдүйг бий болгоход таны оруулж байгаа хувь нэмэр юм.

Дүгнэлт:

Сургалтын оролцогчдоос хүүхдийн эсрэг хүчирхийлэл яагаад гардгийг асуух, хүчирхийллийн мөн чанарыг дахин тайлбарлах, хүчирхийллийн 4 үндсэн хэлбэрийг нэрлэхийг хүсэж, үр дагавар нь хүүхдэд ямар сөрөг нөлөө үзүүлдэг талаар дүгнэлт хийнэ. Хэрэв оролцогчид хүчирхийллийн төрөл хэлбэрүүд, илрэх шинж тэмдэг, түүний хүүхдүүдэд үзүүлэх хор нөлөөг зөв хэлж тайлбарлаж байвал, цааш үргэлжлүүлэх, харин нэрлэж чадахгүй эргэлзэж байвал дахин тайлбарлана. Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах талаар эцэг эх, төр тодорхой үүрэг хүлээдэг гэдгийг тайлбарлана.

Хичээлийн төгсгөлд оролцогчдоос асуулга авна.



Хичээл 2. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх хичээлийн агуулгаар оролцогсдын мэдлэгийг тандах асуулга (хичээлийн өмнө хойно авна)

Асуулга

Таны энэ өдрийн амар амгаланг айлтгая!

Та доорх асуултуудыг анхааралтай уншаад, зөв гэсэн хариултаа дугуйлан тэмдэглэнэ үү.

1. Хүчирхийлэл үйлдэгдэж байгаа үндсэн шалтгаан юу вэ?
 - a) Архидалт
 - b) Ядуурал
 - c) Гэр бүлийн маргаан
 - d) Эрх мэдлийн давуу байдлаа ашиглан бусад хүмүүсийн халдашгүй байдлыг зөрчих
2. Хүүхдэд хамгийн их хор хөнөөл учруулах хүчирхийллийн хэлбэрийг нэрлэнэ үү
 - a) Бие мах бодийн
 - b) Сэтгэл санааны хүчирхийлэл
 - c) Үл хайхрах
 - d) Бэлгийн хүчирхийлэл
 - e) Бүх төрлийн хүчирхийлэл
3. Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд багш ямар үүрэгтэй вэ?
 - a) Эцэг эхтэй нь уулзаж, ярилцах, зөвлөгөө өгөх
 - b) Удирдлагадаа хэлэх, удирдлагаас зөвлөгөө авах
 - c) Багш нартай ярилцаж, зөвлөлдөх
 - d) Холбогдох албан тушаалтанд мэдээлэх
4. Хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд эцэг эх ямар үүрэгтэй вэ?
 - a) Урьдчилан сэргийлэх мэдээлэл өгөх
 - b) Хүүхэдтэйгээ энэ асуудлаар ярилцах
 - c) Багшаас мэдээлэл өгөхийг хүсэх
 - d) Таньдаг хүмүүсээс асуух
 - e) Холбогдох байгууллагад мэдээлэх
5. Таны гэртээ харих замд зодуулсан хүүхэд тааралдвал та ямар арга хэмжээ авах вэ?
 - a) Гэрт нь хүргэж өгнө
 - b) Цагдаагийн байгууллагад хүргэж өгнө
 - c) Сургууль, цэцэрлэг рүү нь хүргэж өгнө
 - d) Надад хамаагүй асуудал
 - e) Сайн хэлж мэдэхгүй байна
6. Чимхэх, түлхэх, хазах нь хүчирхийллийн хэлбэр мөн үү?
 - a) Түлхэх, хазах нь мөн
 - b) Чимхэх бол байж болно
 - c) Бүгд хүчирхийлэл

ТАНД ИХ БАЯРЛАЛАА

ХИЧЭЭЛЭЛЭ:

ХҮҮХЭД ХҮМҮҮЖЛИЙН ЭЭРЭГ АРГУУД






Хичээлийн зорилго:

Эцэг эх/асран хамгаалагчдад хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудаас танилцуулах.

Хүлээгдэж байгаа үр дүн:

Эцэг эх/асран хамгаалагчид хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудаас, түүний зарчмын талаар мэдлэгтэй болно

Өдөр тутмын амьдралдаа хүүхдээ хэрхэн эерэг аргаар хүмүүжүүлж болох талаар үндсэн ойлголттой болно

N°	Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын хэлбэр	Шаардагдах сургалтын материал, хэрэглэгдэхүүн
1	 <p>Сургалтын танилцуулга</p>	2 мин	Чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг	
2	 <p>Үйл ажиллагаа 1: “Хорин таван жилийн дараах таны хүүхэд” дасгал</p>	20 мин	Багаар ажиллах дасгал Хэлэлцүүлэг, ярилцлага Бататгал	Оролцогчдод тараах цаас Оролцогчдод зориулсан өнгийн харандаа, будаг
3	 <p>Үйл ажиллагаа 2: “Та ямар тохиолдолд хүүхдэдээ уурладаг вэ?” дасгал</p>	10 мин	Туршилт Хэлэлцүүлэг, ярилцлага	Алимны цуу 1 шил Цэвэр хөвөн 1 ширхэг Хүнсний сода 1 хайрцаг 2 шилэн аяга 1 амны халбага
4	 <p>Бататгах дасгал</p>	25 мин	Багаар ажиллах Ярилцлага	Бататгах асуултууд
5	 <p>Дүгнэлт</p>	5 мин	Оролцооны арга	

Үйл ажиллагаа 1:

“Хорин таван жилийн дараах таны хүүхэд” дасгал

20 минут

А Оролцогчдын тооноос хамаарч тэднийг 4-5 багт хувааж, ширээнд суулгана. Дараа нь оролцогч тус бүрт нэг ширхэг бичгийн цаас, хар өнгийн харандааны хамт тарааж өгнө. Ширээ тус бүр дээр өнгийн харандаа, будгийн палмастеруудыг хангалттай тоогоор байрлуулсан байна.

Б Дараа нь багш оролцогчдод: “25 жилийн дараах хүүгээ эсвэл охиноо ямар хүн болоосой гэж хүсэж байгаагаа зурах” даалгавар өгнө. Ингэхдээ хүү эсвэл охиноо ЗАН ХАРИЛЦААНЫ хувьд, БОЛОВСРОЛ, АЖИЛ МЭРГЭЖЛИЙН хувьд, ГЭР БҮЛ, НАЙЗ НӨХӨД, ЭРҮҮЛ МЭНД хувьд ямар хүн болчихсон байхыг хүсэж байгаагаа зурагтаа багтаахыг хүснэ. Хүү эсвэл охиныхоо 25 жилийн дараах дүр зургийг аль болох тодорхой зурахыг оролцогчдоос хүснэ. Тухайн цэцэрлэгт 2-с дээш хүүхэд нь явдаг эцэг эхчүүдийн хувьд энэ дасгалыг хийхдээ аль нэг хүүхдээ сонгож, дотроо бодож байгаад зурах даалгавар өгнө. Даалгаврын гүйцэтгэх хугацаа 5 минут

В

Эцэг эхчүүдийг зургаа зурж дууссаны дараа оролцогчдоос төлөөлөл болгон ширээ тус бүрээс 1-2 эцэг эхийг өөрийн зурсан зургаа танилцуулахыг хүснэ

Г

Багш:

Оролцогчдыг зургаа тайлбарлаж бусдадаа харуулж, дууссаны дараа:

“Бүх эцэг эхчүүд хүүхдэдээ хамгийн сайныг хүсч, сайн хүн болохыг хүсч зурсан байгааг бид харлаа. Тэгвэл бид хүүхдээ 25 жилийн дараа ийм сайн хүн болгож хүмүүжүүлж чадаж байна уу?, хүүгээ эсвэл охиноо зорилготойгоор хүмүүжүүлдэг билүү, бид хүүхдээ эрүүл, саруул, ухаалаг, шударга хүн болгож өсгөхийг хүсдэг ч бидний хэрэглэж буй хүмүүжлийн арга эерэг байж чадаж байна уу, хүүхдэдээ шударга, тусч хүний үлгэр дууриаллыг би үзүүлж чаддаг билүү гэдгээ одоо дотроо бодоцгооё”

-гэж хэлэн, эцэг эхчүүдэд хэдэн секунд

бодох хугацаа өгнө.

Д

Дараа нь Багш:

Хүн бүр л хүүхдээ сайн хүн болгож хүмүүжүүлэхийг хүсдэг гэдгийг бид сая хийсэн дасгалаас харлаа. Тэгвэл хүүхдүүд эцэг эхчүүд биднээс юу хүсдэг талаар мэдэж авцгаая.

Хүүхдүүд ээж ааваасаа:

Хэлж ойлгуулах, бурууг тайлбарлаж өгөх

Ганцаарчилж ярилцах

Хүүхдийн санал бодлыг сонсох

Хүүхдэд итгэх, дотоод сэтгэлийг нь ойлгох

Сургамжилж хэлэх

Сануулга өгөх

Захирч тушаахгүй найз мэт харилцах

Хорон үгээр болон муухай үгээр доромжлохгүй байхыг хүсдэг байна.

Гэтэл, эцэг эхчүүдийн хандлага ямар байдаг вэ?

Эцэг эхчүүдийн дийлэнх нь хүүхэд хүмүүжүүлэх эерэг хандлагуудаас мэддэг ч хүч хэрэглэхийг аливаа тулгарсан асуудлыг шийдэх хялбар арга болгон сонгож авдаг. Ингэснээр чихээрээ бус бие махбодын зовиурыг мэдэрч байж сонсдог хүмүүсийг бий болгон өсгөж байна. Өөрөөр хэлбэл, ухамсарлаж ойлгосондоо бус аялдан дагалдагсдыг төрүүлж, итгэл хүндэтгэлийг ухаанаар бус хүчээр олж авах, хандлагатай болдог байна.

Эцэг эхчүүд хүүхдээ бие даасан ертөнц гэдгийг ойлгохыг хүсдэггүй

Хүүхдээ зөвхөн өөрийнхөөрөө байлгахыг хүсдэг

Хүүхдээ хүмүүжүүлэх холын зорилгоо бодохгүйгээр тухайн үед хамгийн хурдан, хялбар, үр дүн муутай аргаар асуудлыг шийдвэрлэх хандлагатай байна.

Одоо бүгдээрээ эцэг эхчүүд бид яагаад уурладаг талаар нэг туршилт хийж үзье.

Үйл ажиллагаа 2:

Та ямар тохиолдолд хүүхдэдээ уурладаг вэ? туршилт 10 минут

Хоёр шилэн аяганы дунд хүртэл алимны цууг ижил хэмжээтэй хийнэ. Багш оролцогчдоос нэг хүнийг сайн дураараа гарч ирэхийг хүснэ. Тэгээд урьдчилан бэлтгэсэн өгөгдөл уншиж өгөх ба энэ явцад бухимдал үүсэх бүрд оролцогчийг аягатай цуун дээр халбага сода нэмж хийхийг хүснэ.

Туршилт # 1: Багшийн ярьж өгөх өгөгдөл

Та ажлын өдөр оройтож сэрлээ. Санд мэнд хувцаслаад, нүүрээ ч угаалгүй автобусны буудал дээр ирж, автобус ирэхийг нилээд удаан хүлээв.

Дараа нь та автобусанд суутал, автобус дүүрэн хүнтэй тул ороод сандал олдсонгүй, зогсоогоороо явав, уур хүрч байна, гэвч хэнд ч юу ч хэлсэнгүй

Ажил дээрээ ирлээ, даргатайгаа үүдэнд таарч зэмлүүлэв, дотроо уур хүрэв

Тэр өдөр бүхэлдээ бухимдалтай өнгөрөв удаан хүлээв.

Орой ажил тарах үед нөхөр, эсвэл эхнэр утсаар залгаж, хүүхдээ цэцэрлэгээс авч чадахгүй, өөрөө аваарай гэв

Цэцэрлэг дээр ирэхэд багш нь танай хүүхдийг айлын хүүхдийг зодсон гэж хэлэв

Энэ үед таны уур хүрсэн бол алимны цуунд 1 халбага сода хийхийг оролцогчоос хүснэ.

Энэ үед таны уур хүрсэн бол алимны цуу нэмэхийг оролцогчоос хүснэ.

Энэ үед таны уур хүрсэн бол алимны цуу нэмэхийг оролцогчоос хүснэ.

Энэ үед таны уур хүрсэн бол алимны цуу хийхийг оролцогчоос хүснэ.

Энэ үед таны уур хүрсэн бол алимны цуунд 1 халбага сода хийхийг оролцогчоос хүснэ.

Энэ үед та яах вэ? гэж оролцогчоос асууна.

Туршилт # 2: Багш

Одоо сая хийсэн туршилтын өгүүлэмжийг өөрчлөн хийж үзье

Та ажлын өдөр оройтож сэрлээ. Гэвч дарга руугаа утасдаж учраа хэлж, оройтох болсондоо уучлал хүсэв.

Автобус дүүрэн хүнтэй ч, нэг залуу танд суудал тавьж өгөв

Ажил дээрээ ирлээ, даргатайгаа үүдэнд таарсан, тэрээр элэгсгээр мэндэлж, өөр юм хэлсэнгүй

Тэр өдөр яагаад ч юм ажил бүтэмжтэй байна

Орой ажил тарах үед нөхөр эсвэл эхнэр утсаар залгаж, хүүхдээ цэцэрлэгээс авч чадахгүй, өөрөө аваарай гэв.

Цэцэрлэг дээр ирэхэд багш нь танай хүүхэд ангийнхаа хүүхдийг зодсон гэж хэлэв. / энэ үед уурласан бол цуунд 1 халбага сода хийнэ, хүүхэдтэй учрыг ярилцсан бол хөвөн хийнэ

Энэ үед та уурласан бол цуунд 1 халбага сода хийж, даргадаа хэлсэн юм чинь хэмээн өөрийгөө тайвшруулсан бол 1 бөөрөнхийлсөн хөвөн аягатай цуунд хийнэ, хөөсрөх эсэхийг ажиглаарай.

Хожигдсондоо гэмшивч суудалд сууж яваа тул цуунд 1 халбага сода, хөвөн зэрэг хийнэ, ажиглана.

Энэ үед уурласан бол цуунд зөвхөн хөвөн хийнэ.

Цуунд 1 хөвөн хийнэ.

Энэ үед уурласан бол цуунд 1 халбага сода хийж, хөөсрөх эсэхийг ажиглана.

Энэ үед та яах вэ? гэж оролцогчоос асууна.

Багшийн өгөх тайлбар:

А

Стресс бол нөхцөл байдлаас үүсэлтэй сэтгэлийн хөдөлгөөн. Тийм учраас болж байгаа үйл явдал, нөхцөл байдлыг хэрхэн хүлээж авах, сэтгэлийн хөдөлгөөнөө хэрхэн зохицуулах нь хүний ухамсраа хянах чадвараас

шалтгаалдаг байна. Саяын туршилт дээр бид яагаад өөртэйгээ адилхан том хүнийг барьж авч зодоогүй хэрнээ хүүхдээ зодсон бэ гэдэг асуудал дээр ярилцлага өрнүүлье. 5 минут

Б

Эцэг эхчүүд хүүхдээ сайн хүн болгох юмсан гэсэн туйлын хүсэлтэй байдаг. Иймээс тэд хүүхдээ буруу зүйл хийхгүй, алдаа гаргахгүй, сахилгагүйтэхгүй, төлөв түвшин сайн хүн болгохыг эрмэлздэг. Энэ бол эцэг эхийн хүүхдээ сайн хүн болгох гэсэн "Холын зорилго"-той байдгийг бид өмнөх дасгалаар баталсан. Хүүхэд, ялангуяа бага насны хүүхэд аливаа зүйлийг сониучирхан, хэлэхгүй авах, таны хэрэгтэй эд зүйлийг эвдэж, хагалж, бас айлын хүүхэдтэй зөв харилцаж чадахгүй нэгнийгээ зодож, бусдын эд зүйлийг булаах үйлдлийг хийдэг ба энэ бүхэн бол хүүхэд орчлон хорвоотой өөрийнхөөрөө танилцаж байгаа л үйл явц юм. Гэтэл байх ёстой зүйл

байрандаа байж, бусдын амнаас хүүхдийнхээ талаар муу үг сонсож, "чихэндээ хонх уях"-ыг зарим эцэг эх тэвчдэггүй. Энэ үед хүүхдээ хүмүүжүүлэх цаг болжээ гэдгийг гэнэт ухаарч, тэгээд ЯАЖ? гэдэг хариултыг хайж эхэлдэг. Бид та бүхэнд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудаас хэрэглэхийг санал болгож байна.

5.4. Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

"Хүүхэд хамгааллын тухай хууль"-аас

В

Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга гэдэг нь хүүхдийн дураар аашлах, дэг журамгүй байх, асуудал гаргахад тэр дор нь яаралтай, хуумгай арга хэмжээ авах, загнаж, зодох БИШ юм. Хүүхдийн хүмүүжлийн эерэг арга нь хүүхдийг аажмаар сахилга баттай болгох, ойлгомжтой

харилцах, хүүхдээ хүндэтгэж, хүүхдийнхээ хүндэтгэлийг хүлээх, хэрхэн зөв шийдвэр гаргахыг хүүхдэдээ зааж ойлгуулах, хүүхдийн чадвар, өөртөө итгэх итгэлийг дэмжих, бусдыг хүндэтгэж сургах явдал МӨН юм¹⁸.

Г

Би та бүхэнд Хүмүүжлийн эерэг аргыг товч танилцуулга видеог (Зураг 1) үзүүлье.

Линк:

<https://www.youtube.com/watch?v=zzbYAG1g4MI>

Зураг 1



Видеог үзүүлж дууссаны дараа Зураг 2 дээр нэмэлт тайлбар хэлж өгнө.
Ингэхдээ, хүүхдийн хүмүүжлийг бид байшин барихтай зүйрлүүлэн харвал:

- Хичээлийн эхэнд хийсэн дасгал болох 25 жилийн дараах хүү/охиноо ямар хүн болгож хүмүүжүүлэхийг хүсч байгаа нь бидний хувьд холын зорилго буюу байшингийн суурь болж байна. Тиймээс та бүхэн хүүхдээ хүмүүжүүлэхдээ өдөр тутам тохиолддог үйл явдал, стрессдээ авталгүйгээр хүүхдээ ирээдүйд ямар хүн болгож хүмүүжүүлэх гэж байгаагаа бодож хүмүүжүүлэх хэрэгтэй.

- Ээж аав нь хүүхдээ хайрладаг гэдгээ бодитойгоор харуулдаг, тайтгаруулан хамгаалдаг, хэлж ярихыг нь сонсож, бодол санааг нь хуваалцдаг, дэмжин туслахыг хүүхэдтэйгээ элэгсэг дотно харилцах гэж хэлэх ба та хүүхэдтэйгээ элгэсэн дотно харилцсанаар таны хүүхэд өөртөө итгэлтэй хүн болж өснө.

- Хүүхдээ ойлгож, хүүхдээсээ юу хүсэж байгаагаа тодорхой ойлгуулаарай. Жишээ нь 4 настай хүүхдэдээ 15 настай хүүхэдтэй ярьж байгаа юм шиг зааварчилгаа өгч болохгүй ба 4 насны хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон аргаар, аливааг тайлбарлан өгч ойлгуулж байгаарай.

- Хүүхэд бүр дахин давтагдашгүй өөр өөр байдаг. Тэдний энэ ялгаатай байдал нь хүүхэд бүрт давуу болон давуу бус талыг бий болгож байдаг. Тиймээс томчууд бид хүүхдийнхээ хувийн онцлог, насны онцлогийг ойлгон мэдсэнээр хүүхдээ ойлгоход тус дөхөм болж, тэдний хөгжилд бодитоор тусалж чадах юм.

- Хамгийн сүүлийн хэсэг буюу байшингийн дээвэр- Асуудлыг шийдвэрлэх: ямар нэгэн асуудал гарвал хүүхдээ хүмүүжүүлэх холын зорилгоо дотроо тунгаан бодож, хүүхэдтэйгээ элэгсэг дотно сэтгэлээр харилцан, аливааг ойлгуулж, хүүхэд хэрхэн бодож сэтгэдэг, юу мэдэрдгийг ойлгосны үндсэн дээр асуудлыг эерэг аргаар шийдвэрлэж байгаарай. Энэ 5 зарчмыг бүхэлд нь ХҮҮХЭД ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭЭРЭГ АРГА гэж нэрлэдэг.

Зураг 2



Бататгах дасгал

25 минут

Багш

Хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэснээр бид хүүхдэдээ аливаа асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, бусдын сэтгэл мэдрэмжийг ойлгож хуваалцах, өөрийгөө хүндэтгэн хайрлах, хүний эрх болон бусдыг хүндэтгэхэд сургаж чадна¹⁹.

Одоо бүгдээрээ өмнө нь ажиллаж байсан дасгал дээрээ дахин нэг ажиллаж үзье. Багш оролцогчдыг 4 багт хувааж баг бүрт дараах өгүүлэмжийг өгнө. Багаараа ярилцан, тус өгүүлэмж дээр гарч байгаа асуудлыг хүмүүжлийн эерэг аргуудаас ашиглан, хэрхэн шийдвэрлэх шийдэл олох даалгавар өгнө. Хугацаа 10 минут.

Нэгдүгээр баг:

Таныг ажлаас тараад ирэхэд хүүхдүүд тань гэр орноо буулгаад, таныг юмаа хураа гэхэд огт сонсоогүй мэт үргэлжлүүлэн нураасаар байна. Энэ тохиолдолд, одоо та хүүхдийнхээ энэ үйлдлийг болиулахын тулд хүмүүжлийн ямар эерэг арга ашиглах вэ?

Хоёрдугаар баг:

Таныг цэцэрлэгээс хүүхдээ авах гээд очиход багш нь: танай хүүхдийг айлын хүүхэд маажсан, багшийгаа битгий гэхэд үгэнд нь ороогүй талаар хэлэв. Багш таныг хүүхдэдээ энэ асуудлыг ойлгуулаарай гэж хэлнэ. Та хүмүүжлийн аргуудаас ашиглан хүүхдэдээ хэрхэн ойлгуулах вэ?

Гуравдугаар баг:

Таны 5 настай хүү ээжийнхээ утсаар тоглож байна. Орон хоолны цаг болж, утсаа болиод хоолоо ид гэхэд хүү үргэлжлүүлэн утсаар тоглосоор байна. Та 2-3 удаа хоолоо ид гэж хэлнэ. Утсаа өгөхгүй, хоол идэхдээ хүртэл утсаар тоглосон хэвээр байна. Энэ тохиолдолд та хүмүүжлийн эерэг арга аргуудаас ашиглан, хэрхэн энэ асуудлыг шийдвэрлэх вэ?

Дөрөвдүгээр баг:

Цэцэрлэгт явах цаг болжээ. 4 настай охин босохгүй нойрмоглоно. Та ажилдаа хоцрох гээд байдаг. Охин босдоггүй. Энэ тохиолдолд охиноо цэцэрлэгт нь цагт нь хүргэх болон ажилдаа хоцрохгүйн тулд та хүмүүжлийн эерэг аргыг ашиглан ямар үйлдэл хийх вэ?

Багуудыг даалгавраа бусад багууддаа танилцуулахыг хүснэ. Энэ үед багш: оролцогчдын хүмүүжлийн эерэг аргын зарчмуудыг хэрхэн амьдралд ашиглаж байгааг, хүүхдийнхээ насны онцлогийг харгалзан үзэж байгаа эсэхийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбарыг хэлнэ.



Дүгнэлт:

Оролцогчдын ажилласан сүүлийн даалгавар дээр үндэслэн, хүмүүжлийн эерэг аргуудыг өдөр тутамдаа хэрхэн ашиглаж, хэвшүүлж болохыг оролцогчдод тайлбарлан дүгнэнэ.

БАГШИД ӨГӨХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ:

2003 – 2006 оны хооронд НҮБ-аас “Хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын судалгаа”-ны тайланд нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эсрэг бие мах бодийн болон сэтгэл санааны шийтгэл түгээмэл байгааг илрүүлж, шийтгэлийг хүмүүжлийн арга хэмээн үзэх хандлага түгээмэл байна.

Хүүхдийн эсрэг бие мах бодь болон бусад гутаан доромжлох шийтгэлийг устгах арга бол эцэг эхчүүдэд хүүхдээ хүчирхийллийн бус аргаар хүмүүжүүлэх хандлагад суралцахад нь дэмжлэг үзүүлэх явдал юм” хэмээн уриалсан байдаг. Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Боловсролын тухай зэрэг хуулиудад

“Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалах даа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ”

хэмээн тодорхойлж, тусгасан. Нийгэмд хүмүүжлийн эерэг аргын тухай шинжлэх ухааны ойлголт, мэдлэг, хандлага хараахан төлөвшөөгүй, арга зүйг түгээн дэлгэрүүлж чадаагүйн улмаас хүүхдэд бие мах бодийн болон сэтгэл санааны шийтгэл, хүчирхийллийг хэрэглэсээр байна. Иймээс эцэг эхчүүдэд хүүхдээ аливаа хүчирхийллээс хамгаалах, өөрсдөө хүчирхийлэл үйлдэхгүй байхын тулд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай байна.

Эцэг эх хүүхдээ ямар хүн болгохыг хүсдэг вэ?

Зүгээр л заавар биелүүлдэг биш, харин ухамсраараа зөв бурууг ялгадаг байхыг хүсдэг. Тэд өөрсдийгөө хажууд нь байхгүй үед хүүхдүүд зөв шийдвэр гаргах чадвартай байхыг хүсдэг төдийгүй зөв зүйл хийгээсэй гэж хүсдэг.

Хүүхдээ бусдыг хэл амаараа болон бие махбодын хувьд доромжилж гэмтээхгүй байхыг хүсдэг.

- Дээрэлхэхгүй
- Өөдгүй, зөвүүн зан гаргахгүй
- Бусад хүүхдийг цохихгүй
- Үерхэж болзож байгаа хүнээ түрэмгийлж доромжлохгүй байх

Хүүхэдтэйгээ сайн харилцаа холбоотой байхыг хүсдэг.

- Дотно ээнэгшил
- Итгэл
- Сайн холбоо харилцаа

Сэтгэл зүйн хувьд эрүүл байхыг хүсдэг.

- Аз жаргалтай байх
- Итгэл найдвартай, өөдрөг байх
- Бухимдал стрессийг даван туулах чадвартай байх

Хүүхдээ аюулгүй байлгахыг хүсдэг

- Гэмтэл бэртлийг аль болох бууруулах
- Эрсдэлийг аль болох бага байлгах

Хүүхдүүдээ асуудал гаргахгүй байхыг хүсдэг.

- Гэмт хэрэгт холбогдохгүй байх
- Бусдын эд хөрөнгийг сүйтгэж, хохирол учруулахгүй байх
- Нийгмийн эсрэг зан байдал гаргахгүй байх
- Нийгмийн хэм хэмжээнд захирагдах

Иймээс 2018 онд “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх” үндэсний аяныг ГБХЗХГ-аас зохион байгуулсан билээ.

Ашигласан материалууд:

- 1 “Хүүхэд хамгааллын үндэс”, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, 2010 он
- 2 “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” Эцэг эх, багш нарт зориулсан 2 боть гарын авлага, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, 2010 он
- 3 Хүмүүжлийн эерэг арга цуврал видео <https://www.youtube.com/watch?v=zzb-YAG1g4MI&t=20s>

Дэлгэрүүлж унших, үзэх материал:

- 1 “Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” Эцэг эх, багш нарт зориулсан 2 боть гарын авлага, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, 2010 он
- 2 Ж. Батдэлгэр, О. Болор, С. Сэлэнгэ “Гэр бүлийн гарын авлага, Бага насны хүүхдийн хөгжил 3-5 нас”, Английн Хүүхдийг Ивээх Сан, Улаанбаатар, 2009 он
- 3 Монгол Улсын Стандарт, Сургуулийн өмнөх боловсрол, бага насны хүүхдийн хөгжил, Улаанбаатар, 2011 он
- 4 Хүүхдийн эрхийн сургалтын дэвтэр, Гүүд Нэйборс Монгол ОУБ, 2015 он
- 5 “Ярилцаж чадвал хамгаалж чадна” эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ ТББ, 2016 он
- 6 Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он
- 7 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 он
- 8 “Гэр бүл – хүүхдийн хүмүүжлийн анхдагч орчин” эцэг эхчүүдийн үндэсний зөвлөгөөний эмхэтгэл, ХНХЯ, ГБХЗХГ, Дэлхийн зөн ОУБ 2017 он

ХИЧЭЭЛ 4:

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛТ НӨХЦӨЛ БАЙДАЛД ОРОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ НЬ

Хичээлийн зорилго:

Энэ хичээлээр эцэг эх/асран хамгаалагчдад бага насны хүүхэдтэй хүчирхийллийн асуудлаар тэр дундаа урьдчилан сэргийлэлт, мэдээлэл өгөх, мөн нууцын талаар хэрхэн ярилцах арга техникт суралцана.

Хүлээгдэж байгаа үр дүн:






Эцэг эх/асран хамгаалагчид бага насны хүүхэдтэйгээ түүний бие эрхтэний аль хэсэг нууц хэсэг болох, түүнийг хэрхэн хамгаалах талаар ярилцах арга техник суралцах

Бага насны хүүхэдтэйгээ учирч болох эрсдэлүүд, муу нууцын талаар, мөн ямар нэг хүчирхийллийн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд хэрхэн мэдээлэх талаар ярилцахад суралцах

Бага насны хүүхдэдээ аливаа эрсдэлтэй нөхцөл, хүчирхийлэлтэй нүүр тулсан үед өөрийгөө хэрхэн хамгаалах талаар ярилцах, дадлага хийлгэх мэдлэгтэй болох

Бага насны хүүхдэд учирч болох хүчирхийллийн талаарх мэдлэгээ бататгах

Бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалахад гэр бүлийн гишүүдийн баримтлах дүрэм, дадал хэвшлийн талаар мэдлэгтэй болж, туршлагажих

N°		Үйл ажиллагаа	Хугацаа	Сургалтын хэлбэр	Шаардагдах сургалтын материал, хэрэглэгдэхүүн
1		Сургалтын танилцуулга	2 мин	Чөлөөт ярилцлага, хэлэлцүүлэг	
2		Үйл ажиллагаа 1: “Цэцэн дүүтэй болсон нь”	20 мин	Багаар ажиллах дасгал Хэлэлцүүлэг, ярилцлага Бататгал	Зурагт хуудас Эрэгтэй, эмэгтэй сургалтын хүүхэлдэй
3		Үйл ажиллагаа 2: “Никитад тохиолдсон явдал” дасгал	15 мин	Дасгал Ярилцлага, хэлэлцүүлэг	Никитад тохиолдсон явдал өгүүлэмж Ширээний театр
4		Үйл ажиллагаа 3: “Гэрийн дүрэмтэй болцгооё” дадлага	18 мин	Дадлага Хэлэлцүүлэг	Оролцогчдын тоогоор цаас, бал
5		Бататгал, дүгнэлт	5 мин	Ярилцлага	


Үйл ажиллагаа 1: “Цэцэн дүүтэй болсон нь”

20 минут

Багш дараах зургийг оролцогчдод үзүүлэн,
дараах эхийг уншиж өгнө.

Зураг 3





Цэцэн дүүтэй болжээ (Зураг 3). Нэг удаа тэр дүүгээ өлгийдүүлэхээс өмнө хартал дүүгийн нь бие Цэцэнгээс өөр байсанд гайхан ээж, ааваасаа яагаад ийм байгааг асуужээ.”

Багш:

Сургалтад оролцож буй эцэг эхчүүдээс нэг аав, нэг ээжийг сайн дураараа гарч ирэхийг хүснэ. Ээжийг Цэцэн охины дүрд, харин аавыг Цэцэн охины аавын дүрд тоглон, Цэцэнгийн асуултад хариулан тоглох даалгавар өгнө.


Дүрд тоглох үеэр багш оролцогчдод эрэгтэй эмэгтэй хүний бие яагаад өөр байдаг, тэдний нэршил болон “хувийн бүс”-ийг зааж, тайлбарлаж өгөхийг сануулна. Оролцогчид дүрд тоглосон сэтгэгдэл, болон өөрсдийн туршлагаасаа хуваалцана. Багш оролцогчдод хүүхэдтэйгээ хүний биеийн онцлог, “НУУЦ ХЭСЭГ”-ийн талаар илэн далангүй ярилцаж байхыг зөвлөнө.

Оролцогчдыг дүрд тоглож дууссаны дараа тухайн дүрд тоглоход ямар байсан, ямар бэрхшээл учирч байсан талаар сэтгэгдлийг нь сонсоорой. Эцэг эхчүүдийн зүгээс бага насны хүүхдэдээ хувийн бүс, нууц эрхтэнгийн талаар илэн далангүй ярилцаж чадахгүй ичих, үг нэршлийг сайн мэдэхгүй байх, хэзээ хэрхэн энэ тухай хүүхэдтэйгээ ярих талаар туршлага байхгүй зэрэг нийтлэг бэрхшээлүүд тохиолддог.

Багш энэ байдлыг харгалзан үзэж, эцэг эхчүүдэд бага насны хүүхэдтэйгээ хувийн бүс, нууц эрхтэнгийн талаар хэрхэн ярилцах, юу хэлэх талаар сургалтын видео (Зураг 4) үзүүлнэ.

Хүүхэлдэйн интернэт линк: <https://www.youtube.com/watch?v=laJyJT1cF-7c&t=5s>

Зураг 4



Дараа нь хүүхэлдэй дээр гарч байгаа нэршил, бага насны хүүхэдтэй ярилцах арга техникийн талаар эцэг эхчүүдийн сэтгэгдлийг асууж, товчхон ярилцаарай.

Жич:

Багш нараа, эцэг эх/асран хамгаалагчдад хүүхдээ усанд оруулах үеэр, эсвэл хувцаслаж байх үедээ "Миний хүү/охины нууц газар нь хаана, хаана байдаг билээ? хэн тэрэнд нь ямар зорилгоор хүрдэг билээ? хэрэв өөр хүмүүс чиний нууц газарт хүрвэл чи яах вэ?" гэж асуун, анги дээр үзсэн агуулгыг гэрт нь бататгаж байхыг зааж өгөөрэй.

Үйл ажиллагаа 2: “Никитад тохиолдсон явдал”²⁰

20 минут

“Никитад тохиолдсон явдал” дасгал

Багш, эцэг эхчүүдэд дараах түүхийг Камишибай²¹ аргаар жүжигчлэн уншиж танилцуулна.

Би та бүхэнд Никита хүүд тохиолдсон явдлыг ярьж өгье. Никита найзуудтайгаа гүйж тоглох дуртай, сэргэлэн хүү юмсанж. Тэр, ээжийгээ “Хоолоо идээрэй!” гэж дуудахад хамгийн түрүүнд хоолны ширээний ард сууж байдаг байлаа. Гэвч нэг өдөр Никита ердийнхөөсөө эрт гэртээ орж ирээд, цонхны дэргэд гудамж руу ширтэн санаа алдан суугаад байлаа.

Хэсэг хугацааны дараа ээж нь бүгдийг нь оройн хоолондоо урилаа. Никита өлсөхгүй байна гээд хоолны ширээнд ирж суусангүй. Ээж нь түүнийг өвдсөн байна гэж бодоод, оронд нь хэвтүүлэн бөөрөлзгөнөтэй цай өгөв. Гэвч Никита унтаж чадахгүй эргэж хөрвөөсөөр байв. Эцэст нь тэрээр дахин цонхны хажууд суун санаа алдаж эхлэв.

..Чи юунд санаа алдав гэсэн сөөнгө хоолойг Никита сонсов. Түүнийг цочин харахад цонхны хажууд томоо гэгчийн шар шувуу сууж байв. Шар шувуу хөлөө зөөн ойртож, хүүг анхааралтай ширтэн:

- За тэгээд чамд юу тохиолдов? гэж асуув.
- Чи хэн бэ? Чи ярьж чаддаг юм уу?
- Би Өвгөн шувуу байна. Би зөвхөн маш гунигтай байгаа хүүхдүүд дээр л нисэж ирдэг юм. Тэгээд чам дээр ирлээ.
- Чи ярьж чаддаг юм уу?
- Тиймээ, гэхдээ чи яагаад гуниглав?
- Аа, би , Никита дахиад л санаа алдлаа.
- Хэрэв чи надад яривал, би чамд тусалж чадна.
- Би чамд тусалж чадахгүй ээ. Би нууц хадгална гэж амласан – гэж хэлэхдээ Никита шивнэн хэллээ.
- Тэгээд чи энэ нууцаасаа болоод хоолоо идэж чадахгүй, унтаж чадахгүй байсан юм уу?
- Тийм ээ.
- Сайн нууц чамайг гунигтай, аз жаргалтай болгодоггүй. Зөвхөн муу нууц л хүүхдийг зовоодог. Харин сайн хүмүүс хүүхдүүдийг муу нууцаа хадгалаасай гэж хүсдэггүй.

Тэгээд Никита өвгөн шувуунд нууцаа хэлэхээр шийджээ.

Манай тоглоомын талбай дээр хааяа нэг ах ирдэг. Тэр бидэнтэй машин, дугуйны талаар ярилцаж, биднийг дандаа чихрээр дайлдаг. Өнөөдөр тэр дахиад ирсэн. Тэгээд биднийг чихрээр дайлж, сонирхолтой юм үзүүлье гэсэн. Дима бид 2 хамт явахаар зөвшөөрсөн. Тэр ах, бид хоёрыг хэн ч байхгүй байшингийн буланд дагуулж очоод бидний биеийн нууц хэсэгт хүрсэн. Дима уйлахад тэр ах биднийг: та хоёр өөрсдөө буруутай учир хэн ч бидэнд итгэхгүй, тиймээс хэнд ч битгий хэл гэж хэлсэн гээд Никита уйллаа.

Өвгөн шувуу хүү рүү ойртоод: "Чи энэ түүхийг ярьсан чинь маш сайн байна. Зарим том хүмүүс

хүүхдүүдэд муу зүйл хийгээд түүнийгээ нуухыг хүсдэг. Чи хүүхэд учир чиний буруу байхгүй. Чамайг хуурч байгаа том хүн л буруутай. Ийм нууцыг хадгалж болохгүй. Ямар нэгэн нууцаас болоод чамд аймаар бас гунигтай байвал чи энэ тухай өөрийнхөө итгэдэг хүмүүстээ заавал хэлэх хэрэгтэй. Эдгээр хүмүүс бол чиний аав ээж, багш, өвөө эмээ чинь байж болно" гэж хэлжээ.

- Намайг тэд загнавал яах вэ?
- Никита чи үнэнийг хэлж, тусламж хүсэх хүсэх хэрэгтэй. Хэрэв тэд чамайг загнавал, чамайг анхаарч сонсох дараагийн хүнийг олох хэрэгтэй. Төгсөө хэсэг бодлогоширсноо:

- **Чамд баярлалаа. Би ээждээ хэлнээ гэв.**

Багш:

Тус түүх дээр юу өгүүлсэн талаар, муу нууцын тухай, эрсдэлтэй нөхцөл байдал үүсч буй тухай, Никита хүү нууцаа яагаад ээждээ хэлээгүй нуусан талаар эцэг эх/асран хамгаалагчидтай товчхон ярилцлага өрнүүлнэ.

Дараа нь энэ тохиолдлоос урьдчилан сэргийлэх талаар хүүхэдтэйгээ хэрхэн ярилцах, хүүхдэдээ ямар үйлдэл хийх талаар, "Аюулгүйн 3 дүрэм"- г (Зураг 5-7) танилцуулах дадлагыг оролцогчдоор хийлгэнэ. Ингэхдээ дадлага хийлгэх зорилгоор оролцогчдыг хос хосоороо нэг баг болж нэг нь Никита хүү болж, нөгөө нь эцэг/эх болон ярилцаж, дүрд тоглох даалгавар өгч, дүрд тоглосон туршлагаасаа хоорондоо хуваалцаж болох юм.

1-р дүрэм:

Үгүй л гэж хэлэн хашхир

Зураг 5



2-р дүрэм:

Зугтаа

Зураг 6



3-р дүрэм:

Итгэж болох хүнд хэл

Зураг 7



Үйл ажиллагаа 3.

“Гэрийн дүрэмтэй болцгооё”

Багш:

Оролцогч бүрт нэг, нэг жижиг цаас тарааж өгнө. Тус цаасан дээр: бага насны хүүхдээ хүчирхийллээс урьдчилан сэргийлэхийн тулд гэр бүлээрээ мөрдөх гэрийн дүрмээ зохиож бичих даалгавар өгнө. Ингэхдээ зөвхөн өөрийн байр сууринаас биш, гэр бүлийн бүх гишүүдийн байр сууринаас давхар бодож бичихийг хүснэ. Энэ даалгаврыг хийх хугацаа 5 минут өгнө.

Гэрийн дүрмийн зарим жишээ:

Зөвхөн гэрийн бүлийн гишүүд мэддэг хаалга тогших нууц кодтой болох. Ингэснээр танихгүй хүн гэрт нь орж, хохирол учруулахаас урьдчилан сэргийлнэ.

Хүүхдүүд рүүгээ орилж хашхирахгүй, аливаа буруу зүйл хийсэн тохиолдолд хүмүүжлийн эерэг аргыг ашиглана.

Бага насны хүүхдээ эрсдэлтэй нөхцөлд ямарч тохиолдолд үлдээж явахгүй байх гэх мэт байж болно.

Дараа нь оролцогчдыг боловсруулсан гэрийн даалгавраа танилцуулахыг хүснэ.

Жич:

Багш та Эцэг эхчүүдэд гэр бүлийнхээ бүх гишүүдтэй хамтдаа дүрмээ боловсруулж ирээд, танилцуулах даалгавар өгч болно.

Дүгнэлт:

Оролцогчдоос бага насны хүүхдийг хүчирхийллийн эрсдэлүүдээс хамгаалахад гэр бүлийн гишүүд, цэцэрлэгийн багш ажилтнууд, төрийн үйлчилгээний нэгж хэрхэн хамтарч ажиллах боломжтой талаар, хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлэх дараалал, хариу авах арга хэмжээг дахин бататгаж асуух ба хангалттай мэдээлэл аваагүй тохиолдолд дахин тайлбарлаж өгнө.

БАГШИД ӨГӨХ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ:

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх нь зөвхөн цагдаа, хуулийн байгууллагынхны хийх ажил биш бөгөөд энэ асуудалд эцэг эхчүүд, иргэд бүх нийтээрээ тэмцэж байж л таслан зогсоож чадна. Үүний тулд хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол бүртэй, таарсан даруйдаа мэдээлэх үүргээ хүлээх нь чухал юм. Мэдээлэхдээ сум, хорооны хамтарсан багийн гишүүд болох цагдаа, эмч, нийгмийн

ажилтан, засаг дарга нарт хандахаас гадна хүүхдийн тусламжийн 108 утсанд мэдэгдэж болно. Эс бөгөөс хүчирхийлэгч ял завших, дахин өөр хүчирхийллийг үйлдэх боломжийг олгодог байна.

Дэлгэрүүлж унших материалууд:

Ж.Батдэлгэр, О. Болор, С. Сэлэнгэ “Гэр бүлийн гарын авлага, Бага насны хүүхдийн хөгжил 3-5 нас”, Английн Хүүхдийг Ивээх Сан, Улаанбаатар, 2009 он

“Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга” Эцэг эх, багш нарт зориулсан 2 боть гарын авлага, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, 2010 он

Монгол Улсын Стандарт, Сургуулийн өмнөх боловсрол, бага насны хүүхдийн хөгжил, Улаанбаатар, 2011 он

Хүүхдийн эрхийн сургалтын дэвтэр, Гүүд Нэйборс Монгол ОУБ, 2015 он

“Ярилцаж чадвал хамгаалж чадна” эцэг эхчүүдэд зориулсан гарын авлага, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ ТББ, 2016 он

Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 он

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2016 он

“Эж аавын ном”, Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр, 2017 он